



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№

1996 оны 6-р сар

№ 6 / 49 /

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|----|--|-----|
| 1. | Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 251 |
| 2. | Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 255 |
| 3. | Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай | 256 |
| 4. | Авилгалын эсрэг хууль | 256 |
| 5. | Эрчим хүчний тухай | 262 |

II. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|--|-----|
| 6. | Авилагалын эсрэг хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 14 | 283 |
| 7. | Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогыг батлах тухай № 22 | 283 |
| 8. | Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай № 23 | 295 |
| 9. | Зарим сумдын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх тухай № 25 | 296 |
| 10. | Эрчим хүчний тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай № 80 | 298 |

III. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|-----|---|-----|
| 11. | Ч.Загиржавт Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгох тухай № 57 | 299 |
| 12. | С.Магауняд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 58 | 299 |
| 13. | Ү.Маамд Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай № 72 | 300 |
| 14. | Д.Алтангэрэлд Монгол Улсын гавьяат хуульч цол олгох | |

- | | | |
|-----|--|-----|
| 14. | тухай № 75 | 300 |
| 15. | Гавдангийн Хатанбаатарыг элчин сайдаар томилох тухай № 107 | 301 |
| 16. | Албан тушаалын зэрэг дэв олгох тухай № 87 | 301 |

IV. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

- | | | |
|-----|---|-----|
| 17. | Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааны талаар № 02 | 304 |
|-----|---|-----|

V. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|-----|---|-----|
| 18. | Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай № 222 | 309 |
| 19. | Хөтөлбөр хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай № 223 | 311 |
| 20. | Улсын хяналтын дүрэм батлах тухай № 227 | 315 |
| 21. | Нийтлэг журам батлах тухай № 228 | 324 |
| 22. | Эрүүл мэндийн даатгалын 1996 оны хураамж, даатгалтай иргэний эмчилгээний зардлын дээд хязгаарыг тогтоох тухай № 242 | 327 |
| 23. | Хүн амын амьжиргааны доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай № 243 | 328 |
| 24. | Иод дутлын эмгэгтэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай № 6 | 329 |

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Н.Ринчиндорж
Нарийн бичгийн дарга	Сан. Жаргалсайхан
Гишүүд	Т.Баасансүрэн Ч.Бавуу Б.Ганбат Б.Янжинлхам
Техник редактор	С.Итгэлт
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б.Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1996 оны 5-р сарын 30-нд
Өрөлтөд 1996 оны 6 дугаар сарын 3-нд. Хэвлэлтэд
1996 оны 6-р сарын 21-нд. Хэвлэлийн хуудас 6,25.
Хэвлэсэн тоо 4700 ширхэг.

Манай хаяг: Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322 838
Засгийн газрын хэвлэх үйлдвэр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

96 оны 4 дүгээр
рын 1-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурд-
наар өөрчлөн найруулсугай:

1/61 дүгээр зүйл:

"61 дүгээр зүйл. Тагнуул хийх

Гадаадын иргэн буюу харьяалалгүй этгээд төрийн нууцад ха-
арах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг гадаад улс, гадаадын бай-
даллага, иргэнд шилжүүлэн өгсөн, шилжүүлэн өгөх зорилгоор хул-
дсан, цуглуулсан, түүнчлэн Монгол Улсын эрх ашигт хохирол
руулахад ашиглахын тулд гадаадын тагнуулын байгууллагын даал-
гвараар бусад мэдээ, баримт бичиг, эд зүйлийг шилжүүлэн өгсөн,
глуулсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял
ийтгэнэ."

2/71 дүгээр зүйл:

"71 дүгээр зүйл. Төрийн нууц задруулах

1. Төрийн нууцад хамаарах объект, тодорхой үйл ажиллагаа, мэ-
дээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцдаг, эсхүл ажил-
ланы үүргийн дагуу мэдсэн этгээд тэдгээрийн нууцыг задруулсан
эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол дөр-
өв жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Албан үүргийн хувьд төрийн нууцыг мэдэх ёсгүй этгээд эрх
ий байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг олж авах зо-
лгоор хайсан, бусдад задруулсан бол гурван жил хүртэл хугацаа-
р хорих ял шийтгэнэ.

3. Төрийн нууцыг задруулсны улмаас хүнд хор уршиг учирсан
гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

3/72 дугаар зүйлийн гарциг, 1 дэх хэсэг:

"72 дугаар зүйл. Төрийн нууц мэдээ, баримт бичиг, биет
зүйлийг үрэгдүүлэх

1. Төрийн нууц мэдээ, баримт бичиг, биет зүйлийг итгэмжлэгдэн
нууцдаг, эсхүл төрийн нууцтай албан үүргийн дагуу танилцсан ал-
тушаалтан, иргэн тэдгээртэй харьцах талаар тогтоосон журам
чсөний улмаас тэдгээрийг үрэгдүүлсэн бол гурван жил хүртэл ху-
ацаагаар хорих ял шийтгэнэ."

4/79 дүгээр зүйл:

"79 дүгээр зүйл. Хууль бусаар Монгол Улсын Хил нэвтрэх

1. Хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун мянгаас дөрвөн зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ хэргийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун тавин мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар: Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын Үндсэн хуульд заасан орогнох эрх олж авахын тулд хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ зүйл хамаарахгүй."

5/111 дүгээр зүйл:

"111 дүгээр зүйл. Биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах

1. Биеэ үнэлсэн хэрэгт захиргааны шийтгэлийн арга хэмжээ авагдсаны дараа нэг жилийн дотор дахин тийм зөрчил гаргасан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Биеэ үнэлэх газрыг зохион байгуулсан, санхүүжүүлсэн буюу буй болгосон, шунахай зорилгоор зуучилсан бол хоёроос дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Хүч хэрэглэж буюу айлган сүрдүүлж, эсхүл насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оруулсан бол гурваас дөрвөн жил зургаан сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

6/172¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Их хэмжээний эд зүйл болон валютын үнэт зүйл, эрдсийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол уг эд зүйлийг хурааж хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин таван мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ."

7/216 дугаар зүйл:

"216 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх

Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн таслан шийдвэртэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн буюу шүүгчийн тогтоолыг санаалтай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зоривд саад учруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас хоёр зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ."

8/256 дугаар зүйл:

"256 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнд садар самууны зүйлсийг тархах

1. Садар самууны хэвлэл, кино, дүрс бичлэг болон тэдгээртэй

адилтгах бусад зүйлийг насанд хүрээгүй хүнд худалдсан, сурталчилсан, өөр хэлбэрээр тараасан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Садар самууны зүйлийг бэлтгэх буюу тараахад насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу хоёр зуун мянгаас дөрвөн зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан үйлдлийг насанд хүрээгүй хүмүүст хүч хэрэглэх, эсхүл садар самууны зүйлийг тараах гэмт хэрэгт урьд ял шийтгэгдсэн этгээд, эсхүл зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдсэн бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

Хоёрдугаар зүйл. Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

1/73¹ дүгээр зүйл.

"73¹ дүгээр зүйл. Хүнийг барьцаалах

1. Бусад этгээдээс мөнгө, хөрөнгө гаргуулахаар болон өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, гүйцэтгэхээс татгалзуулах явдлыг барьцаанд байгаа этгээдийг суллах нөхцөл болгон тавьж уг этгээдийг барьцаалсан бол найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ хэргийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, түүнчлэн насанд хүрээгүй хүнийг болон жирэмсэн эмэгтэйд, эсхүл хэд хэдэн хүнийг барьцаалсан, барьцаанд байгаа этгээдийн амь насанд заналхийлсэн бол долоогоос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ хэргийн улмаас барьцаанд байгаа этгээдэд хүнд хор уршиг учирсан, эсхүл хохирогчийн амь хохирсон нь хүний амины гэмт хэргийн шинжгүй бол наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

2/105¹ дүгээр зүйл:

"105¹ дүгээр зүйл. Хүн хулгайлах

1. Хүн хулгайлсан нь хүн барьцаалах гэмт хэргийн шинжгүй бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Хүнийг дараахь хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлсан:

а/ хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж;

б/ танхай буюу бусад жигшүүрт сэдэлтээр;

в/ жирэмсэн эмэгтэй болон насанд хүрээгүй хүнийг хулгайлсан;

г/ урьдчилан тохиролцсон бүлэг этгээд;

д/ энэ гэмт хэргийг давтан үйлдсэн;

е/ онц аюултай гэмт хэрэгтэн;

ж/ энэ хэргийн улмаас хүний амь болгоомжгүйгээр хохирсон

буюу бусад хүнд хор уршиг учирсан бол долоогоос арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

3/111¹ дүгээр зүйл:

“111¹ дүгээр зүйл. Хууран мэхлэх замаар хүмүүс элсүүлэх

1. Бишийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор хууран мэхэлж хүмүүсийг элсүүлдсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ хэргийг урьдчилсан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг элсүүлдсэн буюу бишийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

4/123¹ дүгээр зүйл:

“123¹ дүгээр зүйл. Мал хулгайлах

1. Бусдын малыг хулгайлсан бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ хэргийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл хээлтэй болон нялх төлтэй эх мал хулгайлсан бол дөрвөөс зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ хэргийн улмаас хохирогч амьдралын эх үүсвэрээсээ салсан, нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж буюу машин механизм ашиглаж, эсхүл айлын хотноос болон гойд ашиг шимт мал, хурдан, жороо морь хулгайлсан, хохирогчийг тохуурхан даажигнаж үйлдсэн бол дөрвөөс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, эсхүл олон тооны мал хулгайлсан бол таваас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Малыг ашиглан шамшигдуулахдаа энэ хуулийн 124, 125, 126, 127, 130 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн бол эдгээр зүйлийг хэрэглэнэ. Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйл нь малыг хулгайлах гэмт хэрэгт хамаарахгүй.”

5/225¹ дүгээр зүйл:

“225¹ дүгээр зүйл. Архивын баримт бичиг хууль бусаар худалдах, шилжүүлэх, дамжуулах

Төрийн архивын сан хөмрөгийн нэгж болж орсон архивын баримт бичгийг хууль бусаар бусдад, эсхүл гадаадын байгууллага, иргэнд худалдсан, шилжүүлсэн, дамжуулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу хоёр зуун мянгаас таван зуун мянган төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

Гуравдугаар зүйл. Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “112 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэсний дараа “мал хул-

гайлах /123¹ дүгээр зүйлийн 2,3,4 дэх хэсэг/, 79² дүгээр зүйлийн "ноштой зөрчсөн" гэсний дараа "буюу Монгол Улсын хилийн дэглэмийг зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсаны дараа нэг жилийн дотор дахин тийм зөрчил гаргасан";

172¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "нэвтрүүлсэн бол" гэсний дараа "уг эд зүйлийг хурааж", 227 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "зайлах" гэсний дараа "болон өөр бусад хэлбэрээр" гэж тус тус нэмсүгэй.

Дөрөвдүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 105 дугаар зүйлийн гарчиггаас "хулгайлах", мөн зүйлийн 1 дэх хэсгээс "хулгайлсан", 227 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс "зэргээр" гэснийг тус тус хассугай.

Тавдугаар зүйл. Эрүүгийн хуулийн 291 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

Зургадугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Долдугаар зүйл. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 4 дугаар
сарын 1-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121 дүгээр зүйлийн 2 дахь заалтын "...79-84" гэсний дараа "172¹" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5/ хил хамгаалах байгууллагын хэрэг бүртгэх алба Эрүүгийн хуулийн 79, 79¹, 172¹ дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар болон хилийн цэргийн анги байгууллагын ажилчин, албан хаагчдаас үүрэгт ажлаа биелүүлэхтэй холбогдуулан үйлдсэн буюу хилийн цэргийн анги, байгууллагын байрлаж байгаа газарт гарсан гэмт хэргийн талаар;"

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 4 дүгээр
сарын 5-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн "тайлбар"-ыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"Тайлбар: Энэ бүлэгт дурдсан албан тушаалтан гэдэгт төрийн улс төрийн, тусгай болон захиргааны албан хаагч, түүнчлэн улс төр, олон нийтийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан хамаарна."

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 196 дугаар зүйлд заасан "тайлбар"-ыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"Тайлбар: Хээл хахууль өгсөн буюу зуучилсан этгээд энэ тухайгаар зохих байгууллага, албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө."

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 4 дүгээр
сарын 5-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВИЛГАЛЫН ЭСРЭГ
ХУУЛЬ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах, гэм буруутай этгээдэд хүдээлгэх хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Авилгалын тухай ойлголт

Авилгал гэж энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээд хээл хахууль авах, хувааа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын байдал, боломжоо ашиглах, ийнхүү ашиглуулахаар түүнд шан харамж буюу хөнгөлөлт, давуу талыг хувь хүн, хуулийн этгээдээс олгох явдлыг ойлгоно.

3 дугаар зүйл. Авилгалын эсрэг хууль тогтоомж

Авилгалын эсрэг хууль тогтоомж нь энэ хууль болон Эрүүгийн хууль, Төрийн албаны тухай хууль, бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

4 дүгээр зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

1. Энэ хуулийн зохицуулалтад дор дурдсан төрийн албан хаагч, бусад этгээд хамаарна:

1/ Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн, захиргааны болон тусгай албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч;

2/ аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга;

3/ зөвшөөрөл буюу эрх олгох, хөнгөлөлт үзүүлэх, зээл тусламж хуваарилах, бүртгэл хийх бүрэн эрх бүхий төрийн албан хаагч;

4/ төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн удирдах болон захиргааны албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч;

5/ төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээд;

6/ төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдэд шан харамж буюу хөнгөлөлт, давуу тал хууль бусаар олгосон иргэн, хуулийн этгээдэд энэ хууль нэгэн адил хамаарна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Авилгалаас урьдчилан сэргийлэх

5 дугаар зүйл. Авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар төрийн бүх шатны байгууллага, түүний удирдлагын хүлээх үүрэг

1. Төрийн бүх шатны байгууллага, түүний удирдлага нь авил-

галаас урьдчилан сэргийлэх талаар дараахь нийтлэг үүрэгтэй байна:

1/ тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, шалгаруулалт хийх зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй, танилцах боломжоор хангах;

2/ төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж буй ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх;

3/ тухайн байгууллагад нэвтрэх, албан хаагчтай уулзах болон иргэдийг хүлээн авах журмыг тогтоох;

4/ энэ хуульд заасан төрийн албан хаагчдын орлогын мэдүүлэгт хяналт тавьж, энэ талаар гаргасан мэдээлэл, гомдлыг шалгаж, шийдвэрлэх.

2. Төрийн бүх шатны байгууллага, удирдах албан тушаалтан нь эрх хэмжээнийхээ хүрээнд авилгалын үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах үүрэгтэй.

3. Төрийн захиргааны төв болон Засгийн газрын дэд бүтцийн байгууллага, шүүх, прокурорын байгууллага байрдаж буй байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага, байрлахыг хориглоно.

6 дугаар зүйл. Төрийн албан хаагчид тавих шаардлага

Төрийн албан хаагчид тавих нийтлэг болон тусгай шаардлага, түүнчлэн тэдгээрт хориглох зүйлсийг энэ хууль, төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуулиар тогтооно.

7 дугаар зүйл. Авилгалаас урьдчилан сэргийлэх зорилгоор хориглох зүйл

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан албан тушаалтан хувийн ашиг хонжоо олох зорилгоор дараахь үйлдэл хийхийг хориглоно:

1/ Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажилдаж байгаа төрийн байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих;

2/ албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүдсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс бэлэг, мөнгөн шагнал, шан харамж авах, талбөргүй бужуу хөнгөлөлттэй үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх;

3/ албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших;

4/ аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гардан эрхлэх, бусдал зуучлан хөглөх;

5/ албан ажлын байдлаа ашиглан зээлээр үнэт цаас, эд хөрөнгө олж авах давуу эрх эдлэх, энэ талаар бусдал давуу байдал олгох, бусдын эрхийг хязгаарлах, төсвийн болон хандивын хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;

6/ албан тушаалынхаа эрх мэдэл, түүнд үндэслэн бусадтай тогтоосон ажил төрлийн холбоо, харилцааг ашиглан өөрийн албан үүргийн хүрээнд үл хамаарах асуудлаар бусад байгууллагын үйл ажиллагаанд шахалт үзүүлэх;

7/ албан тушаалынхаа бүрэн эрхийн дагуу асуудал боловсруулж шийдвэрлэхдээ хууль бусаар аль нэг хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, хууль ёсны шийдвэр гаргахад саад учруулах;

8/ албан тушаалын хувьд ижил зэрэг дэвийн болон өөрт нь захирагддаг буюу хяналт тавьдаг албан тушаалтны үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөхийг оролдох;

9/ албан тушаалынхаа байдлыг ашиглаж хууль бус орлого, ашиг хонжоо давуу тал олох зорилготой бусад үйлдэл хийх.

8 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлэг

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч, түүнд хяналт тавих нь авилгалаас урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээ мөн.

2. Хөрөнгө, орлогын мэдүүлэгт тухайн албан тушаалтан өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас, банкны хадгаламж, мал, орлогын эх үүсвэр болох бусад хөрөнгө, нийт орлого, түүний эх сурвалжийг тусгана.

9 дүгээр зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, түүнд өөрчлөлт оруулах хугацаа

1. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг төрийн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсоны дараа 30 хоногийн дотор болон төрийн алба хааж буй хугацаандаа жил бүрийн 2 дугаар сарын 1-нээс 15-ны хооронд гаргана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанаас өмнө орлогод нь онцгой өөрчлөлт орсон бол тухайн этгээд мэдүүлгийг бүртгэх байгууллага, албан тушаалтанд хоёр сарын дотор энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

3. Мэдэгдлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан нэг сарын дотор мэдүүлэгт өөрчлөлт оруулна.

10 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах байгууллага, албан тушаалтан

1. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг дор дурасан байгууллага, албан

тушаалтан бүртгэж, хадгална:

1/ Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор болон Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын энэ асуудлыг хариуцсан Байнгын хороо;

2/ бүх шатны шүүгчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл;

3/ Засгийн газраас томилогддог албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг төрийн захиргааны албаны зөвлөл;

4/ энэ хэсгийн 1,2,3-т зааснаас бусад этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тэдгээрийг томилох буюу удирдах эрх бүхий албан тушаалтан.

2. Хөрөнгө орлогын мэдүүлгийг маягт, түүнийг бүртгэх, хадгалах журмыг Засгийн газар тогтооно.

11 дүгээр зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн нууц

1. Хөрөнгө, орлогын мэдүүлэг хувь хүний нууцад хамаарна.

2. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн нууцыг хамгаалах, түүнийг ил болгох асуудлыг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулна.

3. Хууль зөрчсөн, гэмт хэргийн шинжтэй гэж үзэх үндэслэл байдал хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан тухайн баримт мэдээллийг бүрэн эрхийнхээ хүрээнд шалган нягтлах буюу эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

4. Тухайн этгээд насны тэтгэвэрт гарсан буюу албан тушаалаас огцорсон, халагдсан тохиолдолд хөрөнгө, орлогын мэдүүлгийг 5 жилийн хугацаанд хадгалсны дараа өөрт нь шилжүүлнэ.

12 дугаар зүйл. Санхүүгийн хяналт

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-3-т заасан этгээдэд дараахь тусгай шаардлага тавигдана:

1/ албан тушаалын байдалтай нь холбогдуулан ёслолын болон албан ёсны бусад арга хэмжээний үеэр хүндэтгэл үзүүлсний болон талархсаны шинж тэмдэг болгож бусад этгээдээс өгсөн бэлэг, дурсгалын зүйлийг байгууллагын санхүүд бүртгүүлэх, сарын цалингаас гадна үнэ бүхий ёслол, дурсгалын зүйлийг тусгах;

2/ хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ мэдүүлэлгүйгээр гадаад улсад хадгаламжийн данс нээлгэхгүй байх.

2. Албан тушаалынхаа сарын цалингаас илүү үнэтэй бэлэг дурсгалын зүйлийг зөрүүт нь төлөх замаар хувьдаа авч болно.

3. төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос бусад орлогын байдлыг нийтэд жил бүр мэдээлнэ.

13 дугаар зүйл. Авилгалаас урьдчилан сэргийлэх
бусад арга хэмжээ

Төрийн зарим байгууллагын онцлог, түүний албан хаагчийн бүрэн эрхийн шинж байдлыг харгалзан тэдгээр байгууллагад авилгалаас урьдчилан сэргийлэх онцлог арга хэмжээг тухайн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон хуулиар тогтоон хэрэгжүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Авилгалын эсрэг хууль тогтоомж
зөрчигчдэд хүлээлгэх хариуцлага

14 дүгээр зүйл. Авилгал үйлдсэн этгээдэд хүлээлгэх
эрүүгийн хариуцлага

Хээл хахуулийн болон авилгалын шинжтэй бусад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуулийн зохих зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

15 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах болон
санхүүгийн хяналтын шаардлага
зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуульд заасан журмын дагуу хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргахаас зайлхийлсэн, хөрөнгө, орлогоо санаатайгаар буруу мэдээлсэн этгээдийг шүүгч 5000-25000 төгрөгөөр, ийнхүү мэдүүлгийг авч хяналт тавих үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр тус тус торгоно.

2. Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг зөрчсөн албан тушаалтныг шүүгч 30000-40000 төгрөгөөр торгоно.

16 дугаар зүйл. Авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнтэй
тэмцэх үүргээ биелүүлээгүй албан
тушаалтанд хүлээлгэх хариуцлага

Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд эрх бүхий албан тушаалтан сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

17 дугаар зүйл. Авилгалын үйлдлийн улмаас учирсан
үр дагаварыг арилгах

Авилгалын үйлдлийн улмаас учирсан хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль бус аливаа шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг Иргэний хууль болон холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

18 дугаар зүйл. Албан тушаалаас огцруулах, халах

Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан заалтыг зөрчсөн буюу авилгал үйлдсэн нь тогтоогдсон бол албан тушаалаас нь хуульд заасан журмаар огцруулах буюу хална.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах болон эрчим хүчээр хангах, түүнийг хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хууль
тогтоомж

1. Эрчим хүчний тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны
тодорхойлолт

Энэ хуульд:

1/ "эрчим хүч" гэж эрчим хүчний нөөцийг ашиглан ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан түүнчлэн шугам сүлжээнээр түгээж байгаа байгалийн хийг хэлнэ;

2/ "эрчим хүчний нөөц" гэж эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглаж болох түлш, цөмийн болон нөхөн сэргэх эх үүсвэрийг хэлнэ;

3/ "хэрэглэгч" гэж эрчим хүчээр хангах гэрээнд эрчим хүчнийг худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгж,

байгууллагыг хэлнэ;

4/ "хангагч" гэж эрчим хүчээр хангах гэрээнд эрчим хүчээр хангах үүрэгтэйгээр оролцож байгаа хуулийн этгээдийг хэлнэ;

5/ "үйлдвэрлэгч" гэж эрчим хүчний үйлдвэрлэл эрхэлж байгаа хуулийн этгээдийг хэлнэ;

6/ "шугам сүлжээ" гэж эрчим хүчийг дамжуулах, хуваарилах зориулалт бүхий байгууламжийг хэлнэ;

7/ "таваарын бүтээгдэхүүн гаргах" гэж эрчим хүчний үйлдвэрлэгч нь 72 цагаас доошгүй хугацаанд төслийн хүч чадлынхаа 60-аас доошгүй хувийг хэрэглээ, хангалтын горимоор тогтвортой ажиллуулж эрчим хүч нийлүүлж эхэлснийг хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Эрчим хүчний талаархи төрийн байгууллагуудын бүрэн эрх

4 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар эрчим хүчний талаар дараахь бүрэн эрхийг сэргэжүүлнэ:

1/ эрчим хүчний тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион зайгуулах;

2/ улсын эрчим хүчний хангамжийн хэтийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

3/ улсын хэмжээнд нөлөөлөл үзүүлэхүйц эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах тухай эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх)-ас сонирхогч этгээдтэй байгуулсан урьдчилсан гэрээг хянаж тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх;

4/ атомын эрчим хүчний нөөцөөр ажиллах эх үүсвэр барьж зайгуулах тухай төрийн захиргааны төв байгууллагаас сонирхогч этгээдтэй байгуулсан урьдчилсан гэрээг хянан үзэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/ эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам, цахилгаан, дулаан хэрэглэх, шугам сүлжээг хамгаалах, эрчим хүчний хяналтын болон эрчим хүчний салбарт ажиллагсдын ахилгын дүрмийг батлах;

6/ гадаад орны эрчим хүчний шугам сүлжээнд холбогдох, алаадас эрчим хүч импортлох, улсын хэмжээний нэгдсэн шугам сүлжээг бүрдүүлдэг төрийн өмчийн гол шугамуудыг гадаадын иргэн,

хуулийн этгээдэд худалдах, түрээслүүлэх тухай асуудлыг шийдвэрлэх;

7/ эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, захиран зарцуулах.

5 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын
бүрэн эрх

Төрийн захиргааны төв байгууллага эрчим хүчний талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ эрчим хүчний тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/ эрчим хүчний салбарын хөгжил, эрчим хүчний нөөц, эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах, хэрэглэх болон эрчим хүчний тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны талаар улсын нэгдсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

3/ эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;

4/ энэ хуулийн 4-р зүйлийн 5-д заасан журмын дагуу эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрхийг мэргэжлийн зохих байгууллага (шашид "мэргэжлийн байгууллага" гэх)-д олгох;

5/ эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглээний талаар нийтлэг мөрдөх журам, зааврыг баталж биелэлтийг хангуулах;

6/ улсын эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний тэнцлийг хянаж батлах, тэнцэлд чадлын дутагдал гарвал эрчим хүчний хангамж, хэрэглээг зохицуулах;

7/ байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед эрчим хүчний хангамжид зайлшгүй шаардлагатай бол тоног төхөөрөмж, эрчим хүчний нөөцийг төрийн өмчийн нэг үйлдвэрлэгчээс нөгөөд шилжүүлэх, бусад өмчлөгчөөс дайчлан гаргуулж нөхөх олговрыг олгуулах;

8/ эрчим хүчний улсын хяналтыг хэрэгжүүлэх.

6 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн

Засаг даргын бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрчим хүчний талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нутаг дэвсгэртээ эрчим хүчний тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, төрийн захиргааны төв байгууллага болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2/ эрчим, хүчний салбарын хөгжлийн улсын нэгдсэн бодлого-

той уялдуулан тухайн нутгийн эрчим хүчний хангамж, хэмнэлтийн бодлогыг боловсруулж төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэх;

3/ нутаг дэвсгэртээ эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний тэнцэлд чадлын дутагдал гарвал эрчим хүчний хангамж, хэрэглээг зохицуулах;

4/ эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглээнд улсын хяналтыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх;

5/ эрчим хүчний хангамжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангуулах, эрчим хүчний тухай хууль тогтоомжийг биелүүлэх талаар нутаг дэвсгэртээ орших үйлдвэрлэгч, хангагчид үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах;

6/ эрчим хүчний үйлдвэрлэлийн осол, саатлаас урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, хохирлыг тогтоох ажилд хяналт тавих, өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, зайлшгүй шаардлагатай бол нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагаас тоног төхөөрөмжийг нөхөх олговортойгоор гаргуулах, хүн хүчний туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах.

7 дугаар зүйл. Эрчим хүчний хангамжийн нэгдсэн сүлжээ, түүний удирдлага

1. Өөр хоорондоо шугам сүлжээгээр шууд холбоотой үйлдвэрлэгч, хангагчид нь үйл ажиллагаагаа нэгдсэн шуурхай удирдлагаар зохицуулах, тэдгээрийн тэгш байдлыг хангах зорилго бүхий эрчим хүчний хангамжийн нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллаж болно.

2. Эрчим хүчний хангамжийн нэгдсэн сүлжээ нь түүнд холбогдсон үйлдвэрлэгч, хангагч, хэрэглэгч болон төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн зөвлөлтэй байна.

3. Эрчим хүчний хангамжийн нэгдсэн сүлжээний ажиллах журмыг Засгийн газар батална.

4. Улсын хэмжээний нэгдсэн шугам сүлжээ бүрдүүлдэг гол шугамууд төрийн өмчид байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл

8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

1. Эрх бүхий байгууллагаас эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон гэрчилгээг тусгай зөвшөөрөл (цаашид "тусгай зөвшөөрөл" гэх) гэнэ.

2. Тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасан журмын дагуу төрийн

захиргааны төв байгууллага буюу түүнээс эрх авсан мэргэжлийн байгууллага олгоно.

3. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.

4. Тусгай зөвшөөрөлд үйлдвэрлэл, борлуулалт явуулах газар нутаг, эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах тоног төхөөрөмж, тэдгээрийг байрлуулах газар, эрчим хүчний нөөцийн төрөл, хүчин чадал, техникийн онцлог, үйл ажиллагаагаа явуулж эхлэх хугацаа зэргийг тодорхой заана.

5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түүнд заасан зүйлүүдийг өөрчлөхдөө тусгай зөвшөөрөл олгосон байгууллагаас зөвшөөрөл авна.

6. Атомын эрчим хүчний нөөцөөр ажиллах эх үүсвэр барьж байгуулах тусгай зөвшөөрлийг Улсын Их Хурал шийдвэрлэснээр, улсын хэмжээнд нөлөөлөл үзүүлэхүйц эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах тусгай зөвшөөрлийг Засгийн газар шийдвэрлэснээр төрийн захиргааны төв байгууллага олгоно.

7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин, хүн амын хэвийн амьдралд хохирол учруулахааргүй аргаар зөвхөн өөрийн хэрэгцээнд эрчим хүч үйлдвэрлэх, өөрийн өмч, эзэмшлийн газар, барилга байгууламжийн дотор шугам сүлжээ барьж байгуулахад зөвшөөрөл авахгүй.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөл гаргах

1. Сонирхогч этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө төрийн захиргааны төв байгууллага буюу мэргэжлийн байгууллагад гаргана.

2. Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.

3. Эрчим хүчний үйлдвэрлэл эрхлэх, эрчим хүчний эх үүсвэр барьж байгуулах тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлд дараахь баримтыг хавсаргана:

1/ техник, эдийн засгийн үндэслэл;

2/ эрчим хүчний нөөцийн судалгаа;

3/ үйлдвэрлэх эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт;

4/ үйлдвэрлэлд ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлтүүд;

5/ үйлчлэх хүрээ, үйлдвэрлэл, хэрэглээний тэнцэл;

6/ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

7/ байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

8/ үйлдвэрлэлийн ослын үед ажиллах горим.

4. Эрчим хүчний борлуулалт эрхлэх, шугам сүлжээ барьж байгуулах тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлд дараахь баримтыг хавсаргана:

1/ борлуулах эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт;

2/ борлуулалт хийх нутаг дэвсгэр, хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэгцээний судалгаа;

3/ шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, эзэмшлийн зааг;

4/ борлуулалтын үйл ажиллагааны нөхцөл.

5. Атомын эрчим хүчний нөөцөөр ажиллах болон улсын хэмжээнд нөлөөлөл үзүүлэхүйц эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулахыг хүссэн этгээд өргөдөлдөө энэ зүйлийн 3,4 хэсэгт заасан баримтаас гадна урьдчилсан гэрээний төслийг хавсаргана.

6. Урьдчилсан гэрээнд тусгай зөвшөөрөл, түүний дагуу байгуулах гэрээний үндсэн нөхцөлүүд, талуудын эрх, үүрэг, хариуцлага, техник, эдийн засгийн үндэслэл болон бусад баримтыг боловсруулах болон урьдчилсан гэрээний хүчинтэй байх хугацаа, тусгай зөвшөөрөл олгох журам, хугацаа зэргийг заана.

7. Урьдчилсан гэрээг дараахь тохиолдолд хүчингүй болсонд тооцно:

1/ эрх бүхий байгууллага хянаж зөвшөөрөөгүй;

2/ тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан этгээд нь урьдчилсан гэрээнд заасан хугацаанд техник, эдийн засгийн үндэслэл болон бусад баримтыг боловсруулж ирүүлээгүй;

3/ урьдчилсан гэрээг эрх бүхий байгууллага хянаж зөвшөөрснөөс хойш 18 сарын дотор хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулаагүй;

4/ урьдчилсан гэрээний үндсэн нөхцөлтүүдийг зөрчсөн;

5/ урьдчилсан гэрээг цуцлахаар талууд тохиролцсон.

10 дугаар зүйл. Өргөдлийг хянан үзэх,

тусгай зөвшөөрөл олгох

1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох албан тушаалтан тусгай зөвшөөрөл авах тухай сонирхогчийн өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудыг хүлээн авч түүнийг хянаж хуулийн шаардлага хангасан эсэхийг тогтооно.

2. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь өргөдөл хуульд заасан шаардлага хангасан бол түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

Өргөдөл нь хуульд заасан шаардлага хангаагүй нь тогтоогдвол түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор буцаана.

3. Төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай гэж үзвэл

өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудын талаар дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн шинжээч томилж болно.

Мэргэжлийн байгууллага шаардлагатай гэж үзвэл өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудыг төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулж болно.

4. Тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан буюу улсын хэмжээнд нөлөөлөл үзүүлэхүйц эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сонирхогчдыг өрсөлдүүлэн шалгаруулах замаар олгож болно.

5. Өрсөлдүүлэн шалгаруулах шалгууруудыг тусгай зөвшөөрөл олгох журмаар тодорхойлно.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа,
түүнийг тооцох сунгах

1. Төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг тухайн үйлдвэр, шугам сүлжээний техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлсон хугацаагаар олгох бөгөөд энэ хугацаа нь 10 жилээс багагүй 60 жилээс илүүгүй байна.

2. Мэргэжлийн байгууллагаас олгох тусгай зөвшөөрлийн хугацаа 10 хүртэл жил байна.

3. Тусгай зөвшөөрлийн хугацааг он, сар, өдрөөр тодорхойлох бөгөөд түүнийг олгосон өдрөөс эхлэн тоолно.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол түүний техник, технологийн найдвартай ажиллагааны байдалтай нь уялдуулан тусгай зөвшөөрлийн хугацааг төрийн захиргааны төв байгууллага 2 удаа тус бүр 20 хүртэл жил, мэргэжлийн байгууллага 5 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно.

5. Хугацааг сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 180-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн
давуу эрх

Үйлдвэрлэгч, хангагч нь тухайн нутаг дэвсгэрт эрчим хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй байгаагаас бусад тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тухайн нутаг дэвсгэрт түүнтэй адил нөхцөлөөр тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.

13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг бусдад
шилжүүлэх, хүчингүй болгох

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрөл болон түүгээр олгосон эрх, хүлээсэн үүргээ төрийн захиргааны төв байгууллага буюу мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх буюу уг эрх, үүргийг өөрчилсөн гэрээ байгуулахыг хориглоно.

2. Тусгай зөвшөөрөл, түүгээр олсон эрх, хүлээсэн үүргээ бусдад шилжүүлэх, шилжүүлэн авахыг хүссэн хоёр тал энэ тухайгаа өргөдөл гаргаж шилжүүлэн авсан эрх, үүргийг зохих ёсоор биелүүлэхээ эрх залгамжлагч этгээд бичгээр нотлон мэдэгдсэн бол төрийн захиргааны төв байгууллага буюу мэргэжлийн байгууллага тийнхүү эрх шилжүүлэхийг зөвшөөрөх эсэхийгээ өргөдөл, мэдэгдэл хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.

3. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь эзэмшигчээс түүнийг сунгуулах тухай өргөдөл гаргаагүй бол анх товлосон он, сар, өдрийн дараагийн ажлын өдөр болмогц дуусгавар болно.

4. Тусгай зөвшөөрлийг түүнийг олгосон байгууллага дараахь үндэслэлээр захиргааны журмаар дуусгавар болгоно:

1/ тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан;

2/ энэ хуульд заасан хугацаанд таваарын бүтээгдэхүүн гаргаж эхлээгүй, үйл ажиллагаагаа хүндэтгэх шалтгаангүйгээр удаа дараа тасалдуулсан;

3/ байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчсөн;

4/ зөвшөөрөлгүйгээр тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн;

5/ хуульд заасан бусад үндэслэл.

5. Мэргэжлийн байгууллага нь энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасан журмыг зөрчиж тусгай зөвшөөрөл олгосон бол төрийн захиргааны төв байгууллага уг тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

6. Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчингүй болгосон нь холбогдогч этгээдийн байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн дагуу
байгуулах гэрээ

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулна.

2. Гэрээнд эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах тоног төхөөрөмж, шугам сүлжээ, тэдгээрийг байрлуулах цэг, эрчим хүчний нөөцийн төрөл, үйл ажиллагаагаа явуулах үе шат, техникийн онцлог, тусгай зөвшөөрөлд заасан хугацаанаас өмнө үйл ажиллагаагаа дуусгавар болгосноос учирсан хохирлыг тооцох журам, талуудын эрх үүрэг, хариуцлага зэрэг асуудлыг тусгана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалт,
түүний аюулгүй ажиллагаа

15 дугаар зүйл. Эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалт,
түүний аюулгүй ажиллагаа

1. Үйлдвэрлэгч, хангагч нь үйлдвэрлэл, борлуулалтын явцад төрийн эрх бүхий байгууллагаас баталсан аюулгүй ажиллагааны дүрэм, түүнийг үндэслэн өөрийн онцлогт тохируулан баталсан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны журам, зааврыг дагаж мөрдөнө.

2. Эрчим хүчний тоног төхөөрөмжийг суурилуулах, ашиглах, шинэчлэхэд мэргэжлийн зохих түвшинг хангасан, төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон инженерийн удирдлагын дор явуулна.

3. Үйлдвэрлэгч, хангагч нь зөвхөн шалгаж баталгаажуулсан өргөх, зөөх механизм, зуух, даралтат сав, шутам хоолой, шахилгаан, механикийн багаж хэрэгсэл ашиглана.

4. Үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлээс гарах байгаль орчныг бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийн хэмжээг хянах хяналт-шиножилгээний багаж хэрэгсэлтэй байна.

5. Үйлдвэрлэгч, хангагч нь зохих аргачлал, маягтын дагуу өөрийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн үзүүлэлтийн бүртгэл хөтөлнө.

6. Үйлдвэрлэгч, хангагч нь үйлдвэрлэлийн осол, саатал, тэдгээрийн шалтгаан бүрийг холбогдох журмын дагуу судлан бүртгэж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга болон төрийн эрх бүхий бусад байгууллагад мэдээлнэ.

7. Улс, бүс нутгийн эдийн засгийн аюулгүй байдал, хүн амын хэвийн амьдралын нөхцөлийг хангахад гүйцэтгэх үүргийг харгалзан тодорхой үйлдвэрлэгчийг тусгай хамгаалалтад байлгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл. Эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөц

1. Засгийн газар нь байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, гэнэтийн бусад аюул учирч эрчим хүчний хангамжинд ноцтой бэрхшээл гарахад хэрэглэх эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

2. Эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцөд үйлдвэрлэгч, хангагчид нийтлэг хэрэглэдэг тоног төхөөрөмж, материал, сэлбэг хэрэгсэл, нүүрс, шингэн түлш зэрэг нөөц хадгалагдана.

3. Эрчим хүчний хангамжийн улсын аюулгүйн нөөцөд хадгалагдах зүйлийн төрөл, хэмжээ, зарцуулах журмыг Засгийн газар

ТОГТООНО.

17 дугаар зүйл. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед эрчим хүчний хангамжийг зохицуулах

1. Засгийн газар байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, гэнэтийн бусад аюулын улмаас нутаг дэвсгэрийн зарим хэсэг, хотын эрчим хүчний хангамж тасалдаж эдийн засаг, хүн амын хэвийн амьдралд сөрөг нөлөө үзүүлэхүйц байдалд шаардлагатай бол зарим үйлдвэрлэгч, хангагчийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд онцгой дэглэм тогтоож болно.

2. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, гэнэтийн бусад аюулын үед үйлдвэрлэгч, хангагч нь тоног төхөөрөмж, эрчим хүчний нөөцийг шилжүүлэн хэрэглэх асуудлыг өмчлөгч, эзэмшигчтэй нь тохиролцон шийдвэрлэнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага тоног төхөөрөмж, эрчим хүчний нөөцийг төрийн өмчийн нэг үйлдвэрлэгчээс нөгөөд шилжүүлэх, бусад өмчлөгчөөс дайчлан гаргуулж нөхөх олговрыг нь тэдгээрийг хүлээн авсан этгээдээс гаргуулна.

4. Өмчлөгч, эзэмшигч нь төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гармагц тухайн тоног төхөөрөмж, эрчим хүчний нөөцийг гарган өгнө.

5. Энэ зүйлийн 3,4 дэх хэсэгт заасан журмаар тоног төхөөрөмж, эрчим хүчний нөөцийг өмчлөгч, эзэмшигчээс дайчлан гаргуулах нь түүнийг үндсэн үйл ажиллагаагаар зогсооход хүргэхгүй байвал зохино.

6. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, нөхөх олговрын талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

18 дугаар зүйл. Шугам сүлжээний хамгаалалтын зурвас

1. Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна.

2. Хамгаалалтын зурвасын дотор барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3. Сум, дүүргийн Засаг дарга хамгаалалтын зурвасын хэмжээг шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу тогтооно.

4. Хамгаалалтын зурвасын дотор тарьсан, ургасан мод бут нь шугам сүлжээнд гэмтэл учруудахаар буюу үзлэг, үйтчилгээ хийхэд саад болохоор бол өмчлөгч, эзэмшигч нь түүнийг шилжүүлэн суулгах, эсхүл тайрах, огтлох үүрэгтэй.

5. Хангагчийн төлөөлөгч, эрчим хүчний улсын байцаагч нь шу-

гам сүлжээнд үзлэг, үйлчилгээ хийх, хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтын зурвасын дагуу бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газар, барилга байгууламжид нэвтрэн орох, дайран өнгөрөх, өмчлөгч, эзэмшигч нь энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй бол уг мод, бутыг шилжүүлэн суулгах, хэрэв боломжгүй бол тайрч огтлох эрхтэй.

19 дүгээр зүйл. Эрчим хүчний нөөц ашиглах

1. Үйлдвэрлэгч нь зураг төсөлд заасан технологийн шаардлага хангасан эрчим хүчний нөөц ашиглана.

2. Эрчим хүчний үйлдвэрлэлд судалж баталгаажуулаагүй буюу технологийн шаардлага хангаагүй эрчим хүчний нөөцийг ашиглахыг хориглоно.

20 дугаар зүйл. Эрчим хүчний ажилтан

1. Үйлдвэрлэгч, хангагч нь ажилтныг гүйцэтгэх ажлынх нь онцлог, хөдөлмөрийн нөхцөл, техник, технологийн шаардлагыг харгалзан эрүүл мэнд, нас, мэргэжил, дадлага, туршлагаар нь сонгон шалгаруулна.

2. Үйлдвэрлэгч, хангагч нь мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах бөгөөд ажилтандаа гүйцэтгэж байгаа ажлын онцлог, онцгой хариуцлага, хөдөлмөрийн нөхцөлтэй нь уялдуулан тогтоосон журмын дагуу цалин хөлс, түүний нэмэгдэл, тусгай хувцас, хөдөлмөр хамгаалах хэрэгсэл зэрэг зүйлийг үнэгүй олгоно.

3. Үйлдвэрлэгч, хангагч нь ажилтнаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4. Үйлдвэрлэгч, хангагч нь ажилтны нийгмийн баталгааг хангах талаар холбогдох үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтын болон бусад гэрээ байгуулан ажиллана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Эрчим хүчний үнэ, тариф.

Эрчим хүчний хөрөнгө оруулалтыг дэмжих

21 дүгээр зүйл. Эрчим хүчний үнэ, тариф

1. Нэгдсэн сүлжээнд холбогдсон хангагчид нь зөвхөн Засгийн газраас эрх олгосон байгууллагаас энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан зарчим, хэрэглэгчийн эрх ашигт нийцүүлэн хянаж зохицуулсан үнэ, тарифаар эрчим хүчийг борлуулна.

2. Нутгийн захиргааны байгууллага, хангагч, хэрэглэгчдийн төлөөлөгчид нэгдсэн сүлжээнд холбогдоогүй хангагчаас борлуулах эрчим хүчний үнэ, тарифыг энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан зарч-

мыг үндэслэн хамтран тогтооно.

3. Эрчим хүчний үнэ, тарифыг хянаж зохицуулахад дараахь зарчмыг баримтална:

1/ үнэ, тариф нь үнэн зөв тооцсон зардал, ашгийн нийлбэр байх;

2/ үнэ, тариф нь чанарын үзүүлэлт, хэрэглээний горим зэргээс хамааран ялгавартай байх;

3/ нэгдсэн сүлжээнд холбогдсон ижил нөхцөл, горимоор эрчим хүч авч байгаа хэрэглэгчдэд ялгавартай үнэ тогтоохгүй.

4. Үйлдвэрлэгч, хангагч нь үнэ, тарифын өөрчлөлтийн талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй бөгөөд тийнхүү мэдэгдсэнээс хойш 10-аас доошгүй хоногийн дараа өөрчлөгдсөн үнэ, тарифыг мөрдөж эхэлнэ.

5. Зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Засгийн газар эрчим хүчний үнэ, тарифыг бүс нутгийн хөгжил, эрчим хүчний үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлоготой уялдуулан зохицуулж болно.

6. Эрчим хүчний үнэ, тарифыг хянаж зохицуулах эрх бүхий байгууллага нь үйлдвэрлэгч, хангагчийн үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгаж, шаардлагатай бол өртөг зардалаа хямдруулахыг түүнд даалгаж болно.

22 дугаар зүйл. Эрчим хүчний хөрөнгө оруулалтыг дэмжих

1. Эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах аж ахуйн нэгж, байгууллагад зээлийн баталгаа гаргаж өгөх, Засгийн газрын шугамаар авч байгаа гадаадын зээл, тусламжаас олгох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, шинэчлэх зориулалтаар гадаад орон, олон улсын байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээдээс олгож буй буцалтгүй тусламжийн бараа, тоног төхөөрөмж болон эрчим хүчийг хилээр нэвтрүүлэхэд гаалийн болон худалдааны албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

2. Засгийн газар эрчим хүч хэмнэлттэй зарцуулдаг, ашигт үйлийн коэффициент өндөртэй эрчим хүчний тоног төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан хэрэгслийг импортлож байгаа аж ахуйн нэгж, байгууллагад худалдааны албан татварын хөнгөлөлт үзүүлдэг.

3. Нөхөн сэргэх эрчим хүчний нөөцөөр ажиллах эх үүсвэр, тоног төхөөрөмжийг импортлох, тэдгээрийг ашиглан эрчим хүч үйлдвэртэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар, гаалийн болон худалдааны албан татварын хөнгөлөлт үзүүлдэг.

4. Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээг барьж байгуулах,

үйлдвэрлэлийн үндсэн технологийг шинэчлэхэд хөрөнгө оруулсан монголын аж ахуйн нэгж, байгууллагыг оруулсан хөрөнгийн хэмжээгээр орлогын албан татвараас эхний 10 жилд бүрэн чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувь хөнгөлнө.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хэрэгцээнд эрчим хүч үйлдвэрлэх, өөрийн өмч, эзэмшлийн газар, барилга байгууламжийн дотор шугам сүлжээ барьж байгуулахад хамаарахгүй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Эрчим хүчний хэмнэлт, хэрэглээ

23 дугаар зүйл. Эрчим хүчний хэмнэлт

1. Эрчим хүчний тоног төхөөрөмжийн эрчим хүч зарцуулалтын зөвшөөрөгдөх дээд хэмжээг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас илүү хэмжээний эрчим хүч зарцуулдаг эрчим хүчний тоног төхөөрөмжийг хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

3. Эрчим хүч зарцуулалтын хэмжээ, ашигт үйлийн коэффициент, аюулгүй ашиглах заавар, аюулгүйн бусад анхааруулгагүй эрчим хүчний тоног төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэх, импортлохыг хориглоно.

4. Үйлдвэрлэгч, хангагч, хэрэглэгч бүр эрчим хүчийг хэмнэлттэй горимоор үйлдвэрлэх, түгээх, хэрэглэх талаар төрийн эрх бүхий байгууллагуудаас тогтоосон журмыг биелүүлэх үүрэгтэй.

5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барилга байгууламжийг төлөвлөх, барих материалыг сонгохдоо төрийн захиргааны төв байгууллага болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан журмыг мөрдөнө.

24 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг

1. Хэрэглэгч нь Иргэний хуульд зааснаас гадна дараахь эрх эдэлнэ:

1/ хангагч нь эрчим хүчээр хангах гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохнолдола дутуу нийлүүлсэн, гэрээнд заасан тоо, хэмжээ, чанарын үзүүлэлт бүхий эрчим хүчээр хангаагүй эрчим хүчний үнийг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэхээр хангагчаас нэхэмжлэх;

2/ энэ хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлснээс учирсан хохир-

лоо нөхөн төлүүлэх.

2. Хэрэглэгч иргэн Иргэний хуулийн 227 дугаар зүйлд зааснаас гадна дараахь үүргийг биелүүлднэ:

1/ цахилгаан, дулааны эрчим хүч хэрэглэх болон тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг биелүүлэх;

2/ хууль тогтоомжийн дагуу хангагчаас эрчим хүчээр хангах техникийн нөхцөл авсан байх;

3/ эрчим хүчээр хангах техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан байх;

4/ хэмжэлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийн шаардлага хангасан тоолуур, хэмжүүртэй байх;

5/ өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах.

3. Хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараахь үүргийг биелүүлднэ:

1/ эрчим хүч зарцуулалтын тайланг гарган тогтоосон журмын дагуу мэдээлэх;

2/ гэрээнд заасан эрчим хүчийг заасан хугацаандаа авахгүй болсон талаар хангагчид 3-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх;

3/ өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах ажлын төмөр ажиглуулах.

25 дугаар зүйл. Үйлдвэрлэгч, хангагчийн

эрх, үүрэг

1. Хангагч нь Иргэний хуулийн 228 дугаар зүйлд зааснаас гадна дараахь эрх, үүргийг хэрэгжүүлднэ:

1/ тусгай зөвшөөрөл авснаас хойш 18 сарын дотор таваарын бүтээгдэхүүн гаргах;

2/ эрчим хүчний тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, эрчим хүчний чанарын үзүүлэлтийн зохистой хэмжээг дагаж мөрдөх;

3/ эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах ажлын явцыг тусгай зөвшөөрөлд заасан хугацааны дагуу үе шат тус бүрээр нь төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэх;

4/ үйл ажиллагаагаа тусгай зөвшөөрлийн хүрээнд тасралтгүй явуулах, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээг өөрчлөх, өргөтгөхөд зохих зөвшөөрөл авах;

5/ хууль тогтоомжийн дагуу хэрэглэгчид эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох;

6/ үйлдвэртэл, борлуулалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайланг төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагад гаргаж өгөх;

7/ үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн бүрмөсөн зог-

соох шаардлагатай бол 18 сараас доошгүй хугацааны өмнө төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх;

8/ эрчим хүчний хангамжийг тодорхой хугацаагаар хязгаарлах шаардлагатай бол хэрэглэгчдэд 4-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэх;

9/ эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээ, хангамжийн горимоор зохицуулагдах зогсолтоос бусад тохиолдолд эрчим хүчний хангамжийг халаалтын улиралд 4 цагаас илүү, халаалтын бус улиралд 12 цагаас илүү хугацаагаар хязгаарлахгүй байх;

10/ эрчим хүчний хангамжийн горимыг зөрчих буюу хэрэглэгчдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц байдлаар үйл ажиллагаагаа тодорхой хугацаагаар зогсоох шаардлагатай бол нэгдсэн сүлжээнд ажиллаж буй хангагч нь сүлжээний удирдлагад, нэгдсэн сүлжээнд холбогдоогүй хангагч нь тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад 6 сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэж зөвшөөрөл авах.

2. Үйлдвэрлэгч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

1/ тусгай зөвшөөрөл авснаас хойш 5 жилийн дотор таваарын бүтээгдэхүүн гаргах;

2/ үйлдвэрлэж буй эрчим хүчээ өөрөө борлуулах буюу хангагчаа сонгон түүнтэй гэрээ байгуулан дамжуулан борлуулах;

3/ хуулийн 21 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсэгт заасны дагуу хянаж зохицуулсан үнэ, тарифт багтаан дамжуулан борлуулж буй эрчим хүчний үнэ, тарифыг хангагчтай тохиролцох;

4/ эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах өргөх, зөөх төхөөрөмж, зуух, даралтат сав, шугам хоолой, цахилгаан, механикийн багаж хэрэгслийг холбогдох дүрэмд заасан хугацаанд шалгаж баталгаажуулах;

5/ эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн бүрмөсөн зогсоох шаардлагатай бол 5 жил, тодорхой хугацаагаар зогсоох шаардлагатай бол 6 сараас доошгүй хугацааны өмнө төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх.

3. Үйлдвэрлэгч, хангагч нь хууль тогтоомж, гэрээнд заагаагүй нөхцөл, болзол тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлахыг хориглоно.

26-дугаар зүйл. Эрчим хүчээр хангах гэрээ

1. Хангагч, хэрэглэгч нь хууль тогтоомжид нийцүүлэн эрчим хүчээр хангах гэрээ байгуулна.

2. Иргэнтэй байгуулах эрчим хүчээр хангах гэрээнд хэрэглэх эрчим хүчний хэмжээ, чанар, төлбөр, тооцооны журам, гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг, хариуцлага, торгууль, алдангийн хэмжээ, хохирлыг тооцох журам, шаардлагатай бусад асуудлыг тусгана.

3. Аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах эрчим хүчээр хангах

гэрээнд энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна эрчим хүчний хэрэглээний горим, сар бүрийн хуваарь, хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагын харилцах данснаас төлбөрийг банкны байгууллагаар шууд хийлгэх нөхцөл, төлбөрийн барьцаа шаардлагатай бусад асуудлыг тусгана.

4. Хангагч нь хэрэглэгчийн төлбөрийн чадварын талаар харилцагч банкны байгууллагаас гаргасан баталгааг үндэслэн эрчим хүчээр хангах гэрээг байгуулж болно.

5. Хангагч нь гэрээлсэн эрчим хүчний үнэ, тариф, чанарт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгчдэд мэдэгдэх буюу хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана.

6. Хэрэглэгч энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 10 хоногийн хугацаанд багтаан хангагчтай байгуулсан гэрээндээ зохих өөрчлөлт оруулаагүй нь уг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

7. Хангагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эрчим хүчээр хангах гэрээ байгуулахаас болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах эрхгүй.

8. Хангагч, хэрэглэгч нь гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, эрчим хүчний тасалдал, түүний шалтгааныг тухай бүр хамтран тогтооно.

27 дугаар зүйл. Эрчим, хүчний төлбөр хийх,
торгууль ногдуулах

1. Хэрэглэгч нь эрчим хүчээр хангах гэрээнд өөрөөр заагаагүй бол сард хэрэглэх эрчим хүчний үнийн 30 хувьтай тэнцэх төлбөрийг тухайн сарын 10-ны өдрийн дотор урьдчилан төлнө.

2. Хэрэв талууд эрчим хүчний төлбөрийн талаар тохиролцон гэрээнд заасан бол банкны байгууллага хугацаандаа төлөөгүй эрчим хүчний төлбөрийг хангагчийн нэхэмжлэлийн дагуу хэрэглэгчийн харилцах данснаас шууд хийнэ.

3. Хэрэглэгч нь эрчим хүчний хангамжийг тасалдуулсан буюу гэрээлсэн тоо, хэмжээ, чанарын үзүүлт бүхий эрчим хүч нийлүүлээгүй хангагчид тасалдуулсан эрчим хүчний үнийн дүнгийн 5,0 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.

4. Хангагч, хэрэглэгч нь эрчим хүчээр хангах гэрээнд торгуулийн хэмжээг энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас өөрөөр тогтоож болно.

5. Хангагч нь гэрээнд заасан хугацаанд эрчим хүчний төлбөрөө төлөөгүй хэрэглэгчид хугацаа хожимдуулсан хоног тутамд төлбөрийн дүнгийн 0,5 хүртэл хувьтай тэнцэх алданги ногдуулна.

6. Хангагч хэрэглэгчээс эрчим хүчний төлбөрийг бусад төрлийн төлбөртэй хамт хийхийг шаардах эрхгүй.

28 дугаар зүйл. Эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлэх

1. Эрчим хүчний улсын байцаагч дараахь тохиолдолд үйлдвэрлэгч, хангагчийн эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим тоног төхөөрөмжийн ашиглалтыг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлдэг болно:

1/ үйлдвэрлэлийн осол гарах болон ажиллагсдын эрүүл мэнд, амь насанд аюул учруулахуйц нөхцөл байдал бий болсон;

2/ үйлдвэрлэн гаргаж буй эрчим хүч нь стандарт, чанарын үзүүлэлтийн шаардлага хангахгүй байгаа;

3/ эрчим хүчний улсын байцаагчаас тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй;

4/ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө биелүүлээгүй буюу бусад хэлбэрээр байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг зөрчсөн;

5/ техник, технологийн үндсэн шийдлийн аюулгүй ажиллагаа, үр ашгийн үзүүлэлтийг бууруулан өөрчилсөн.

2. Эрчим хүчний улсын байцаагч дараахь тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлдэг болно:

1/ хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон;

2/ эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл буюу техникийн нөхцөлийн шаардлагыг зөрчсөн;

3/ эрчим хүчний тоолуур, хэмжүүр, тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан;

4/ гэрээнд заасан төлбөр, тооцооны болон бусад үүргээ биелүүлээгүй.

3. Хангагч, хэрэглэгчийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх эрх бүхий ажилтан нь шийдвэртээ түдгэлзүүлэх болсон шалтгааныг тодорхой зааж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, тоолуур, хэмжүүр, залуур болон шаардлагатай бусад хэрэгслийг битүүмжилнэ.

4. Энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасны дагуу эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлсэн нь хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг зөрчөөгүй бусад үйлдвэрлэгч, хангагч, хэрэглэгчийн эрхийг хөндөхгүй.

5. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлсэн үйлдвэрлэгч, хангагч, хэрэглэгч нь түдгэлзүүлсэн шалтгааныг арилгасан тухайгаа түдгэлзүүлсэн эрх бүхий ажилтанд мэдэгдэж шалгуулахаас өмнө битүүмжилсэн тоног төхөөрөмж, шугам сүлжээг ашиглахыг хориглоно.

6. Эрчим хүчний хэрэглээг нь түдгэлзүүлж болохгүй хэрэглэгчдийн жагсаалтыг Засгийн газар батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хяналт, хариуцлага

29 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

1. Эрчим хүчний тухай хууль тогтоомжийн биелэлтэд эрчим хүчний улсын хяналтын байгууллага, түүний байцаагч мэргэжлийн хяналт тавина.

2. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага эрчим хүчний хангамж, мөрдөж буй үнэ, тарифын үндэслэлд олон нийтийн хяналт тавина.

30 дугаар зүйл. Маргааныг хянан шийдвэрлэх

1. Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээтэй холбогдож гарсан маргааныг холбогдогч талууд зөвшилцөн шийдвэрлэж чадаагүй бол маргааныг шүүх шийдвэрлэнэ.

2. Эрчим хүчний төлбөр, тооцоотой холбогдуулан эрх бүхий байгууллага, ажилтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргасан тохиолдолд асуудлыг шүүх шийдэх хүртэл уг шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээтэй холбогдуулан эрх бүхий байгууллага, ажилтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргасан нь уг шийдвэрийг биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

31 дүгээр зүйл. Хохирлыг нөхөн төлөх

1. Эрчим хүчний тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн эсэхийг үл харгалзан учруулсан хохирлыг хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

2. Хангагч гэрээний үүргээ ёсоор биелүүлдэггүй буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эрчим хүчийг тасалдуулсны улмаас хэрэглэгчид учруулсан шууд хохирлыг нөхөн төлнө.

3. Хэрэглэгч нь хангагч гэрээний үүргээ биелүүлдэггүй буюу зохих ёсоор биелүүлдэггүйгээс өөрт учирсан шууд бус хохирлыг эрчим хүчээр хангах гэрээнд өөрөөр заагаагүй бол шүүхэд нэхэмжлэн шийдвэрлүүлнэ.

4. Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн ослын улмаас хэрэг-

лэгчид учирсан шууд болон шууд бус хохирлыг хангагчаар нөхөн төлүүлэх асуудлыг хууль тогтоомж, эрчим хүчээр хангах гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

5. Энэ хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасны дагуу эрчим хүчний хангамжийг тодорхой хугацаагаар хязгаарлах тухай мэдэгдсэн байхад хэрэглэгч өөрийн буруугаас хохирол хүлээсэн бол хохирлыг хангагч хариуцахгүй.

6. Хэрэглэгч нь эрчим хүч ашиглах журам, горим, гэрээг зөрчиж хууль бусаар хэрэглэсэн эрчим хүчний үнийг нөхөн төлнө.

7. Хууль тогтоомж, эрчим хүч хэрэглэх горим, гэрээг зөрчиж хэрэглэсэн эрчим хүчний хэмжээг тогтоохдоо холбогдогч этгээдийн эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид хийсэн хамгийн сүүлчийн шалгалтаас хойшхи хугацаанд авч буй хэрэглээний чадлаар тооцож тогтооно.

32 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1. Эрчим хүчний тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Эрчим хүчний тухай хууль тогтоомжийг дараахь байдлаар зөрчсөн гэм буруутай этгээдэд шүүгч болон эрчим хүчний улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/ үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаатай холбоотой бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах журам зөрчсөн албан тушаалтныг 30000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000 хүртэл төгрөгөөр торгох;

2/ эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээг зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн, техник, технологийн үндсэн шийдлийн аюулгүй ажиллагаа, үр ашгийн үзүүлэлтүүдийг бууруулсан, эсхүл технологийн шардлага хангаагүй буюу шалгаж баталгаажуулаагүй эрчим хүчний нөөцийг хэрэглэсэн бол албан тушаалтныг 10000-30000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;

3/ хууль тогтоомж, гэрээнд заагаагүй нөхцөл, болзол тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарласан, энэ хуулийн 28 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлсэн, эсхүл эрчим хүчний хязгаарлалтын тухай хэрэглэгчдэд энэ хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасан хугацаанд мэдэгдээгүй буюу хугацаа хожимдуулан мэдээлсэн албан тушаалтныг 25000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгох;

4/ эрчим хүчийг зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэн борлуулсан,

тусгай зөвшөөрөл, түүгээр олгосон эрх, хүлээсэн үүргээ зөвшөөрөл-гүйгээр бусдад шилжүүлсэн, энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсэгт заасны дагуу хянаж зохицуулснаас өөр үнэ, тарифаар эрчим хүчийг борлуулсан албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

5/ эрчим хүчний улсын байцаагчийн шаардлагыг биелүүлээгүй, улсын хяналт хэрэгжүүлэхэд нь саад учруулсан буюу шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дэглэм зөрчсөн иргэнийг 1000-5000 төгрөгөөр, албан тушаалтныг 5000-15000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

6/ хангагчтай гэрээ байгуулахгүйгээр буюу тоолуур, хэмжүүргүйгээр эрчим хүчийг хэрэглэсэн, эсхүл гэрээнд зааснаас өөрөөр холболт хийх, эрчим хүчний тоолуурын байрлал, битүүмжлэл, эд ангийн хэвийн ажиллагааг алдагдуулсан, эсхүл эрчим хүч зарцуулалтын тайлан гаргах журам зөрчсөн бол иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 60000 хүртэл төгрөгөөр аж ахуйн нэгж, байгууллагыг 200000 хүртэл төгрөгөөр торгох;

7/ байгалийн гэмшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, гэнэтийн бусад аюулын үед төрийн захиргааны төв байгууллага болон эрчим хүчний улсын байцаагчийн шийдвэрийг биелүүлээгүй иргэнийг 20000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох.

3. Эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалтын явцад тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөн, мөн энэ хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг зөрчиж битүүмжлэсэн эд зүйлийг дур мэдэн захиран зарцуулсан этгээдэд Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4. Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон онцгой дэглэмийг зөрчсөн, эсхүл үйлдвэрлэлийн томоохон ослын шалтгааныг нуун дарагдуулсан, түүнийг тогтооход саад учруулсан этгээдэд эрүүтийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч буюу сумын Засаг даргын шийдвэрээр 20000-50000 төгрөгөөр торгох буюу 21 хүртэл хоногоор баривчлах шийтгэл ногдуулна.

33 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1. Энэ хуулийг 1996 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2. Энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

3. Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үе шат-

тайгаар хэрэгжүүлж 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс да
мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 4 дүгээр
сарын 5-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

**Авилгалын эсрэг хуулийг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай**

Авилгалын эсрэг хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/ Авилгалын эсрэг хуульд Засгийн газрын холбогдох шийдвэрийг нийцүүлэх;

2/ Авилгалын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маягт, журмыг 1996 оны 6 дугаар сарын 1-ний дотор баталж мөрдүүлэх;

3/ төрийн байгууллагуудыг нэгдсэн байруудад байрлуулах боломжийг судлан шийдвэрлэх зэргээр энэ хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг 1996 оны 3 дугаар улиралд багтаан дуусгах.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 4 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

**Монгол Улсын төрөөс баримтлах
хүн амын бодлогыг батлах тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого"-ыг савсралтын ёсоор баталсугай.

Дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

Улсын Их Хурлын 1996 оны
22 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС БАРИМТЛАХ ХҮН АМЫН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улс нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг зорьж байгаа, цөөн хүн амтай, өргөн уудам нутагтай, хүн амын нягтрал бага, насны бүтэц залуу, нүүдлийн болон суурин соёл иргэншил хосолсон, хөгжиж байгаа орон мөн.

Хүн амын бүтэц, байршлын энэхүү онцлогтой байдал нь Монгол Улсын төрөөс баримтлах Хүн амын бодлого /"Хүн амын бодлого" гэх/ өвөрмөц байхын үндэс болно.

2. Хүн амын бодлого нь тус улсын Үндсэн хуульд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд болон хүн ам тогтвортой хөгжлийн хүрээнд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэмжээнд тулгуурлана.

3. Монгол Улсын хөгжил дэвшлийн үндэс нь оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш хөгжилтэй, эх оронч үзэлтэй, ёс суртахууны өндөр соёлтой, хөдөлмөрч, хууль ёсоо дээдэлдэг хүн гэж үзнэ. Хүн амын бодлого нь хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх, хувь хүн, гэр бүлийг хөгжүүлэх зорилго бүхий хүн төвтэй хөгжлийн дэлхий нийтийн үзэл баримтлалыг иш үндэс болгоно.

4. Хүн амын бодлого нь Монгол Улсын хөгжлийн ойрын ирээдүйн буюу 21-25 жилийн хугацаанд хүн амын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох хүн ам, тогтвортой хөгжлийн тулгуур баримт бичиг мөн.

5. Хүн амын бодлогын зорилго нь хүн амаа тогтвортой өсгөх, өв тэгш хүмүүжүүлэх, хүний бүх талын хөгжлийн нийгэм, эдийн засаг, орчин ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

6. Хүн амын энэхүү бодлогыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг иш үндэс болгон улс орны нийгэм, эдийн засгийн жил бүрийн үндсэн чиглэлд тусгах замаар хэрэгжүүлнэ.

7. Хүн амын бодлого нь дараахь хэсгээс бүрдэнэ:

- 1/ Хүн амын өсөлт, эрүүл мэндийн талаар;
- 2/ Хүн амын хоол хүнс, орон байрны талаар;
- 3/ Хүн амын боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн талаар;
- 4/ Хүн амын байршилт, шилжих хөдөлгөөний талаар;
- 5/ Хүн амын бүртгэл, мэдээлэл, судалгааны талаар;

- 6/ Хүн ам, тогтвортой хөгжлийн уялдааг хангах талаар;
- 7/ Гэр бүл, хүн амын нийгмийн бүлгийн байдлын талаар;
- 8/ Хүн амын бодлогын удирдлага, нөөцийн талаар.

Хоёр. Хүн амын өсөлт, эрүүл мэндийн талаар

8. Хүн амын өсөлтийн талаар баримтлах бодлогын зорилт нь 2010-2015 он хүртэлх хугацаанд хүн амын жилийн дундаж өсөлтийг 1,8 хувиас бууруулахгүй тогтвортой хадгалах, 1990 оны түвшингээс нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг гуравны нэ-гээр, эхийн эндэгдлийн түвшинг тэн хагасаар тус тус бууруулах, монгол хүний дундаж наслалтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

9. Төрөлтийг эх хүүхдийн эрүүл мэндэд тохиромжтойгоор зохицуулах таатай нөхцөл бүрдүүлэх явдал нь хүн амын өсөлтийг хангах хүчин зүйл гэж үзнэ.

10. Эх нялхсын эндэгдлийг тууштай бууруулах нь хүн амын өсөлтийг хангах нэг гол хүчин зүйл гэж үзэж, эсэн мэнд амаржих, өсч торних нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарна.

11. Хүн амд нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл аж төрөх ёсны мэдлэг олгож эмэгтэйчүүдийг нас бие гүйцээгүй байхдаа буюу хэт ойрхон төрөхөөс сэргийлэхэд чиглэсэн сурталчилгаа, эмнэлэг, үйлчилгээг өөрийн орны онцлогт тохируулан явуулна.

12. Үр хөндөлтийг хүсээгүй хүүхдээ төрүүлэхээс зайлсхийх арга болгон хэрэглэхийг дэмжихгүй бөгөөд эмнэлгийн заалтаар болон гэр бүлийн гишүүдийн эрх ашгийн үүднээс мэргэжлийн эмч, эмнэлгийн баталгаатай нөхцөлд үр хөндөлтийг хуулиар зохицуулна.

13. Өмчийн олон хэвшилд түшиглэсэн эрүүл мэндийн байгууллагын зохистой тогтолцоог бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эн тэргүүнд тавих, орчин цагийн болон үндэсний уламжлалт анагаах ухааны хосломжийг бүх талаар дэмжих үндсэн дээр эмнэлэг-үйлчилгээний чанарыг олон улсын стандартын төвшинд хүргэх зорилт тавина.

14. Нарийн мэргэжлийн оношлогоо, эмчилгээ, үйлчилгээ, сургалт, судалгааны төвүүдийг бүс нутагт байгуулахыг бүх талаар дэмжих үндсэн дээр эрүүл мэндийн өндөр зэрэглэлийн үйлчилгээг хөдөөгийн хүн амд ойртуулах бодлого баримтална.

15. Удамшлын өвчин, эмгэг согог, оюун ухааны хомсдолтой хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх эмнэлэг удамшил зүйн хяналтын тогтолцоо бий болгож, иргэдийн овгийг сэргээх ажлыг нийтийн хүртээл болгоно.

16. Эх нялхсын эрх ашгийг хамгаалахад зориулах хөрөнгө оруу-

лалтыг нэмэгдүүлэх, эх, хүүхдэд үзүүлж байгаа нийгмийн халамжийн арга, хэлбэрийг нийгмийн хөгжлийн шаардлагатай уялдуулан зохицуулна.

17. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчин, осол эндэгдлээс сэргийлэх, өвчлөл, нас баралтыг бууруулах эмнэлэг, нийгмийн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Гурав. Хүн амын хоол хүнс, орон байрны талаар:

18. Хүн амын хоол хүнсний хангамжийг хүн амын өсөлттэй уялдуулах, үйлдвэрлэл, хэрэглээний зохистой уялдааг тогтвортой хангах гол зарчмыг мөрдлөг болгоно. Энэ талаар төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын хүнсний хууль, хүнсний хөтөлбөр зэрэг хууль эрхийн бусад акт баримтаар баталгаажуулна.

19. Хүн амын хүнсний аюулгүй байдал, орон сууцны болон орчин ахуйд тавих эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг бүх талаар чангатгана.

20. Монгол хүний хоол хүнсний хоногийн физиологийн нормыг нас, хүйс, ажил, мэргэжил, нутаг дэвсгэр, уур амьсгалын онцлогтой уялдуулах, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний үндэсний лавлахыг бүсчлэн тогтоож, хангах, зарчим баримтална.

21. Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, өндөр настангууд болон нийгмийн эмзэг бүлгийн хоол тэжээлийн бүтэц, найрлагыг тэдний физиологийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн төгөлдөржүүлэх судалгаа, үйлдвэрлэлийг дэмжинэ.

22. Хүн амыг үндэсний уламжлалт гэр, сууцаар хангахад чиглэсэн аливаа үйлдвэрлэл, үйлчилгээнд байнгын дэмжлэг үзүүлэх зарчмыг төрийн бодлогын анхааралд байлгана.

Хот, суурин газрын нөхцөлд монгол хүний соёл иргэншил, эрүүл ахуйн шаардлага хангасан, үндэсний хэлбэр, ур хийцийг шингээсэн өрх гэр бүлийн аж ахуй, жижиг үйлдвэрлэл эрхлэх нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн хямд төсөр орон сууцны тогтолцоо бүрдүүлэх аливаа санаачлагыг тал бүрээр дэмжинэ.

Дөрөв. Хүн амын боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн талаар:

23. Ажиллагсадынхаа боловсролын түвшин, техник, технологийн мэдлэг, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд оруулсан хөрөнгийн хэмжээтэй уялдуулан аж ахуйн нэгж, байгууллагад санхүү, эдийн засгийн зохих дэмжлэг үзүүлдэг байх чиглэл баримтална.

24. Өмчийн аль ч хэвшилд түшиглэсэн мэргэжлийн боловсрол олгох сургалтыг хөдөөгийн хүн амд ойртуулах үүсгэл санаачилгыг эн тэргүүнд дэмжинэ.

25. Монгол Улсын иргэн бүр өөрийн хүсэл сонирхол, авьяас чадварынхаа дагуу бүтээлч хөдөлмөр эрхлэж өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд төрөөс бүх талын дэмжлэг үзүүлнэ.

26. Монгол айл, өрх бүр, ялангуяа бага орлоготой иргэд, олон хүүхэдтэй эхчүүд гэрээрээ жижиг үйлдвэртэл эрхлэхэд нь бүхий л дэмжлэг тусалцаа үзүүлэх чиглэл баримтална.

27. Төв суурин газраас хэт аслагдсан нутаг, говийн бүсийн хүн амаас аливаа хэлбэрийн үйлдвэртэл эрхлэх таатай нөхцөл бүрдүүлнэ.

Тав. Хүн амын байршилт, шилжих хөдөлгөөний талаар:

28. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдалагын зохистой тогтолцоо, нийгэм, соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд ойртуулах явдал бол хүн ам хот, хөдөөд жигд тархан суурьших гол нөхцөл гэж үзнэ.

29. Байгаль орчны даац, хүн амын өсөлт, нийгмийн үйлчилгээний тэнцвэртэй харьцааг хослуулах үндсэн дээр хот, сууринг монгол хүний сэтгэл зүйд нийцсэн үндэсний өвөрмөц хэв шинжтэй хөгжүүлэх чиглэл баримтална. Нийслэл болон томоохон хотын хүн амын хэт төвлөрөлийг багасгах, дагуул хотууд бүс нутгийн төвүүдийг хөгжүүлэхэд түлхүү анхаарна.

30. Монголд байнга оршин суух гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн тоо, бүтэц болон ажиллах хүч оруулах, гаргах, тус улсын иргэд цагаачлахтай холбогдсон асуудлыг улс орны аюулгүй байдал, хүн амын өсөлт, нийгэм эдийн засгийн хөгжлийн цаг үеийн шаардлага, хүний эрхийг хүндэтгэх, харилцан ашигтай байх зарчимд нийцүүлэн төрөөс зохицуулна.

31. Монгол Улсын иргэд гадаадад түр шилжин суурьшихтай холбогдсон гэрээ хэлэлцээрт иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг тусгаж, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настны эрх ашгийг хамгаалахад онцгойлон анхаарна.

Зургаа. Хүн амын бүртгэл, мэдээлэл, судалгааны талаар:

32. Иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдүүлж, үйл ажиллагааг нь тогтвортой хангах бодлого баримтална.

33. Орчин үеийн судалгаа шинжилгээний арга зүй, ололтод үндэслэн Монгол хүн судлал, хүн ам, хөгжлийн судалгааг өргөжүүлнэ.

34. Хүн ам судлал, хүн ам, хөгжлийн асуудлаар үндэсний мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, сургалтын бааз чадавхийг хөгжүүлэх, сургалтын бүтэц, агуулгыг олон улсын жишигт хүргэж боловсронгуй болгох чиглэл баримтална.

Долоо. Хүн ам, тогтвортой хөгжлийн уялдааг хангах талаар:

Дэлхий ертөнцөд хүйтэн дайн төгсгөл болж улс төрийн уур амьсгал нааштай зөөлөрсөн хэдий ч туйлын ядуурал, өлсгөлөн, ажилгүйдэл, өвчин зовлон, цагаачлал, хүрээлэн буй орчны бохирдол, угсаатны хүчирхийлэл зэрэг олон асуудал дэлхийн хамтын нийгэмлэгийн сэтгэлийг түтшээх боллоо. Энэ бүхнийг иш үндэс болгон хүний аюулгүй байдлын нөхцлийг хангахад хүн ам ба тогтвортой хөгжлийн төрийн бодлогыг хангах үндэс нь нийгмийн хөгжлийн төвд хүний асуудлыг тавих явдал гэж үзнэ.

35. Хүн ам, тогтвортой хөгжлийн уялдааг хангах талаар баримтлах бодлого нь байгаль орчны даац, хүн ам, эдийн засгийн тогтвортой өсөлтийн харьцааг хангах үндсэн дээр хүн амын сайн сайхэн амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

36. Хөгжлийн төлөвлөлтийг хүн амын хүчин зүйлтэй уялдуулах, ялангуяа хүний нөөцийг бүрэн ашиглах зарчим баримтална.

37. Иргэд эрүүл байх, урт наслах, тасралтгүй сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгэм, соёлын амьдралд тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлэхэд нөөц баялгийг зохистой хуваарилахын зэрэгцээ хүний хөгжилд зориулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэл баримтална.

38. Байгаль цаг уурын өвөрмөц орчин, нүүдэл, суурин соёл иргэншил хосолсон, өргөн уудам нутагтай Монгол орны нөхцөлд тохирсон нийгмийн баримжаа бүхий хүн төвтэй хөгжлийн "Монгол загвар"-ыг боловсруулж хэрэгжүүлнэ.

39. Байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах нөөц баялгийг зохистой, хэмнэлттэй ашиглах замаар хүний амьдрал аж төрөх талтай орчныг бүрдүүлэхэд анхаарна.

40. Хүн ам, байгаль орчин, соёл иргэншил, тогтвортой хөгжлийн мөн чанар, хоорондын зүй тогтолт холбооны талаар бүх нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлнэ.

Найм. Гэр бүл, хүн амын нийгмийн бүлгийн талаар:

41. Гэр бүл, хүн амын нийгмийн бүлгийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль болон Хүүхдийн эрхийн тухай

Конвенц, Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Найробын стратеги, Настангуудын талаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны Венений төлөвлөгөө, Тахир дутуу хүмүүсийн эрхийн тухай тунхаглал, хүн ам ба хөгжлийн асуудлаархи Кайрын бага хурал, Нийгмийн хөгжлийн асуудлаархи Копенгагены Дэлхийн дээд хэмжээний уулзалт, дэлхийн эмэгтэйчүүдийн Бээжингийн дөрөвдүгээр бага хурал зэрэг НҮБ-ын баримт бичгүүдэд дэвшүүлсэн үзэл санааг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

А. Гэр бүлийн хөгжлийг хангах талаар:

42. Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын анхааралд байлгана.

43. Гэр бүлийн орчинд үндэсний дэвшилттэй ёс заншил, соёл иргэншлийн өв уламжлалаа хадгалах, сэргээх, өвлөн хөгжүүлэхийг эрхэмлэн хүндэтгэнэ.

44. Гэр бүл эдийн засгийн талаар бие даан хөгжих чадавхиа дээшлүүлэх, өмч хөрөнгөө өсгөн арвижуулах аливаа шударга санаачлага, үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

45. Гэр бүлийн хөгжилд туслах нийгмийн үйлчилгээг хүүхдийг хүмүүжүүлэх төлөвшүүлэх, өндөр настныг халамжлах, нийгмийн эрүүл мэнд, ахуйн соёлын нөхцлийг сайжруулахад чиглүүлнэ.

46. Гэр бүлийн төлөвшил, хөгжилд өрхийн тэргүүний үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, гэр бүлийн гишүүдийн тэгш эрхийг хангаж, ялгаварлан гадуурхах, шоовдорлох, хүчирхийлэх аливаа илэрлийг хориглох бодлого баримтална.

47. Гэр бүлийн орчинд хүмүүнлэг ёсноос гажууд адал балмад явдал, садар самууныг сурталчлах зэрэг ёс бус үйл ажиллагааг монгол уламжлал, зан, заншилд үл нийцнэ гэж үзнэ.

Б. Хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх талаар:

Хүүхдийн талаархи олон улсын конвенц, тунхаглал холбогдох баримт бичгүүд болон Монгол Улсын үндсэн хуулийг иш үндэс болгон улс орны ирээдүй хөгжлийг хангах гол нөөц, хүч болох хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх, тэдний эсэн мэнд өсч бойжих, сурч боловсрох, аж төрөх таатай нөхцлийг бүрдүүлэх төрийн бодлогыг дараах чиглэлүүдээр тодорхойлж байна:

48. Хүүхдэд Монголын ард түмний түүх, соёл, ёс суртахууны дэвшилтэт уламжлалыг өвлүүлж, хүн төрөлхтний соёл иргэншлийн үнэт зүйлийг эрхэмлэх, хүнлэг энэрэнгүй ёс, эрх чөлөө, тэгш эрх, эв санааны нэгдлийг дээдлэх, байгалийг хайрлах, бүтээлч хөдөлмө-

рөөрөө аж төрөх үзэл дадлаар хүмүүжүүлэх орчин нөхцөлийг гэр бүл, сургууль, нийгэмд бүрдүүлнэ.

49. Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдэд ертөнцийг танин мэдэх, ажил амьдралын байр сууриа зөв сонгоход нь туслах, хүмүүнлэг ёсонд сургах, тэднийг эрүүл өсгөж төлөвшүүлэх журамт үүрэг хүлээнэ.

50. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгж бүр хүүхдийг багаас нь боловсон зөв хүмүүжиж төлөвшихөд нь туслахад чиглэсэн нийгмийн эрүүл орчин бүрдүүлэх, ёс суртахууны дэвшилт уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, зааж сургах үүрэг хүлээдэг байх зарчим баримтална.

51. Байгаль орчин, нүүдэл, суурин иргэншлийн онцлог, хот, суурин газрын үндэсний намба төрхийг хослуулан хөгжүүлэх үндсэн дээр төр, гэр бүл, нийгмийн зүгээс хүүхдийн нүд, сэтгэл зүйд нийцэхүйц таатай орчин, амьдралын зохистой хэрэгцээний стандарт бүрдүүлэхийг үнэт баялаг хэмээн эрхэмлэн үзнэ.

52. Монгол орны соёл иргэншил, нийгэм, эдийн засгийн харилцааны онцлогтой уялдуулан хүүхдийн сэтгэл, оюун санаа, бие бялдар, физиологийн хөгжлийн үндсэн зүй тогтолыг илрүүлэн тогтоох, мэдээллийн сан байгуулах, хүүхдийн өв тэгш хөгжлийг хангах асуудалд судалгаа шинжилгээний ажлыг чиглүүлнэ.

53. Хүүхдийг эцэг эхийн ивээл хайр асрамжинд эсэн мэнд бойжих, бие махбодь, оюун санааны хувьд эрүүл байх, элдэв халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүрээлэн байгаа орчныг эрүүлжүүлэх, тэднийг эрүүл аж төрөх дадал заншилд сургах, эрүүл мэндээ хамгаалах иргэний ухамсартай болгон төлөвшүүлэхэд төрийн бодлого чиглэгдэнэ.

54. Хүүхдийг 18 нас хүртэл эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцна.

55. Хүүхдийг хөхөөр хооллох, бие сэтгэлийн хөгжилд нь тохирсон хоол хүнсээр хангах, бие бялдар, оюун санааны өсөлт, хөгжилд хяналт тавих, хүүхдийн өсөлт, эрүүл мэндийн шаардлагад нийцсэн бичил махбодь, аминдэм, ялангуяа иод, төмөр, Д,С аминдэмээр баялаг хоол тэжээлийн үйлдвэрлэлийг төрөөс дэмжинэ.

56. Хүүхэд гэр бүл, эцэг эхийн амьжиргааны чадавхиас болж хүнсний дутагдал, тураал, өлсгөлөнд нэрвэгдэхээс хамгаалахад чиглэгдсэн олон нийтийн санаачилгыг төрөөс бүх талаар дэмжинэ.

57. Эрэмдэг солонтой хүүхдэд үзүүлэх эмнэлэг, нийгмийн халамжийг тасралтгүй зохион байгуулах, нөхөн сэргээх тоног төхөөрөмжөөр хангах, бие бялдар болон оюуны хөгжлийн онцлогт тохирсон сургалтанд хамруулах, мэргэжлийн баримжаа олгох ажлыг онвчтой хэлбэрээр зохион байгуулна.

58. Монгол хүүхдийн сэтгэл зүй, эрүүл мэнд, бие бялдарын онц-

лог, байгаль цаг уурын эрс тэс нөхцөлд тохирсон гутал, хувцасаар хангах чиглэлийн үйлдвэртэл худалдааг дэмжинэ.

59. Үндэсний хэл, бичиг, соёл эрдэм мэдлэг, уламжлалт гүн ухаан уран сайхны өвөрмөц сэтгэлгээ, зан заншил, соёлын дэвшилтэт өвийг суурь болгон, хүүхдийг хөгжүүлэх, хүмүүжүүлэх, сургах, амьдралд бэлтгэх үйл ажиллагааны агуулга арга, технологийг хүн төрөлхтний оюуны үнэт зүйл, шинжлэх ухаан технологийн ололт, чиг хандлагатай нягт уялдуулан боловсронгуй болгон хөгжүүлэхийг зорино.

60. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартыг олон улсын нийтлэг жишиг, үндэсний уламжлалыг харгалзан нарийвчлан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, агуулга, арга технологийг боловсронгуй болгоно.

61. Багш бэлтгэхэд тусгайлан бодлого, барьж, багш болох авьяас сонирхолтой хүнийг зөв сонгон, багш бэлтгэх сургуулиудын сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгож, материаллаг хангамжийг сайжруулна.

62. Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх, эрдэм боловсрол эзэмшихэд нь идэвхтэй нөлөө үзүүлэхүйц шинжлэх ухаан, танин мэдэхүй, уран зохиол, техник, зохион бүтээх, ахуйн хэрэглээний ном зохиол, сурах бичгээр хангах чиглэл баримтална.

63. Хүүхдийн оюуны хэрэгцээг нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хангахад чиглэсэн соёл урлагийн бүтээлийг урамшуулан дэмжинэ.

64. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, харилцан бие бие нээ хүндэтгэх, хамтарч ажиллаж, амьдарч, сурах, хариуцлага хүлээх чадвар, сэтгэцийн дархлалтай болгоход чиглэсэн хүүхдийн олон нийтийн байгууллага, үүсгэл санаачилгын хөдөлгөөнийг дэмжин, хүүхдийн өөрийн удирдлагыг хөгжүүлнэ.

65. Шинэ зууны иргэн төлөвшүүлэх зорилгод нийцсэн, хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон залгамж, цэгцтэй мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр боловсруулж мөрдөн, хүүхдийн мэдлэг хүмүүжил, ёс суртахуунд эерэг нөлөө үзүүлэхүйц мэдээллийн орчин бүрдүүлнэ.

66. Эцэг, эх, гэр бүл, сургууль нь хүүхдийн авьяас билгийг багаас нь илрүүлэх, эрдэм боловсрол эзэмшүүлэх, авьяас, сонирхол, оюуны чадавхаа түшиглэн амьдралаа тэтгэн хөгжүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг эрүүл мэнд, боловсрол, ёс суртахуунд нь тохирох хэлбэрээр зохион байгуулах, хөдөлмөрлөх дадал эзэмшүүлэх, тэднийг хөдөлмөрлөж байж хүний жишигтэй амьдарна гэдэг ёс суртахууны идэвхтэй зарчимд сургах үүрэг хүлээнэ. Хүүхдийн хөдөлмөрийг эрүүл мэнд, боловсрол, ёс суртахуунд нь тохирох хэлбэрээр зохион

байгуулах, хөдөлмөрлөх далал эзэмшүүлэх, дэс дараатай бодлогыг гэр бүл, сургууль болон нийгмийн бүх хүрээнд баримтална.

67. Хүүхдийг хүмүүнлэг ёс, байгаль орчин, үндэсний соёл иргэншил, ёс заншил, дэвшилт уламжлалынхаа мөн чанарыг мэдэрч, дээдлэн хүндэддэг, хууль ёс, эрх үүргээ гүнээ ухамсарласан иргэн болгон хүмүүжүүлэх бодлогыг төрөөс баримтална.

68. Хүүхдэд эцэг, эх, үр хүүхдийн элбэрэл журам, багш шавийн барилдлагыг дээдлэх ёс суртахууны мэдрэмж, ухамсар төлөвшүүлэхийг эрхэмлэнэ.

69. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн үндсийг иж бүрэн бүрдүүлж, хүүхдийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төр, олон нийтийн хяналтыг хүчтэй болгоно.

70. Нийгмийн болон насанд хүрэгчдийн зүгээс хүүхдэд учруулж болзошгүй аливаа дарлал, мөлжлөг, доромжлол, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авна.

71. Өнчин, тахир дутуу, эмгэг согогтой хүүхдийг төрийн ивээл халамжинд байлгаж, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд тусална. Бага насны өнчин хүүхдийг үрчлүүлэх, асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоох, ийм хүүхдийг асарч хүмүүжүүлж байгаа гэр бүл, иргэдэд туслах чиглэл баримтална.

72. Үндэстний цөөнхийн хүүхэд эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, зан заншлаа өвлөх эрмэлзлэлийг хүндэтгэнэ.

73. Хүүхдийн төлөө анхаарал халамж тавьж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллагын үйл ажиллагаа, тэдний зүгээс хүүхдийн сайн сайхны төлөө хөрөнгө хуримтлуулах сан байгуулах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

74. Хүүхдийн төлөө үйл ажиллагаанд улс үндэстний анхаарлыг төвлөрүүлэх, нийгмийн бүх нөөц хүчийг татан оролцуулах, тэдний хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөрийг аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр боловсруулж мөрдөнө.

В. Залуучуудын талаар:

75. Залуучууд төлөвшин хөгжих эрх зүй, эдийн засаг, нийгмийн үндсийг хөгжүүлэхэд төрийн бодлого чиглэгдэнэ.

76. Эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа хөгжүүлэхэд чиглэсэн залуучуудын санаачилга, үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.

77. Залуучуудад эрх зүйн мэдлэг олгох, байгаль орчин, эх хэл, бичиг үсэг, ёс заншил, соёл иргэншил, удмын сангаа дээдлэх үзлийг төлөвшүүлэх, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх таатай орчин бий болгоход чухалчлан анхаарна.

78. Авыгас чадавхиа хөгжүүлэх, эрдэм мэдлэгэд шамдан суралцах,

насан туршдаа өөрийгөө тэтгэх мэргэжил, амьдрах ухааны арга барил эзэмших, орон байртай болох оюуны бүтээл, туурвилаа чөлөөтэй хөгжүүлж, үр шимийг нь хүртэхэд залуучуудад дэмжлэг үзүүлнэ.

79. Дэлхийн улс орны залуучуудтай хатран ажиллаж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, эх орноо хөгжүүлэх, эх дэлхийгээ энх амгалан байлгахад чиглэсэн Монголын залуучуудын үйл ажиллагаа, үүсгэл санаачилгыг дэмжинэ.

Г. Эмэгтэйчүүдийн талаар:

80. Улс төр, нийгэм, эдийн засаг, гэр бүлийн хүрээнд эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, тэднийг хөгжил дэвшилд идэвхтэй оролцуулахад төрийн бодлого чиглэгдэнэ.

81. Охид, эмэгтэйчүүд, эхчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд энэ талаар боловсрол олгох үндсэн дээр эрүүл эхээс эрүүл хүүхэд төрүүлэх боломжийг бүрдүүлэхэд голлон анхаарна.

82. Эмэгтэйчүүдийн боловсрол мэргэжлийн түвшинг дээшлүүлэн авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх боломжоор хангаж, тэднийг нийгмийн амьдрал, хөгжилд өргөн оролцуулахыг тухалчилна.

83. Үндэсний ёс заншил, гэр бүлийн харилцааны уламжлалд тулгуурлан охид, эмэгтэйчүүд, эхчүүдэд гэрийн эзэгнэйн мэдлэг боловсрол эзэмшүүлэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.

84. Үр хүүхдээ эрүүл энх өсгөж, амьдрах арга ухаанд сургаж хүмүүжүүлсэн эх хүний хөдөлмөр, зүтгэлийг улс орныхоо хөгжилд оруулсан чухал хувь нэмэр гэж үзэж ёс суртахуун, эрх зүйн үнэлэмжийг дээшлүүлнэ.

85. Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдэл, чадавхийг дээшлүүлэхэд туслах, тэдний хөдөлмөр зохицуулалтыг боловсронгуй болгох, гэрээр болон бүтэн бус өдрөөр хөдөлмөрлөх боломжийг өргөтгөх, ялангуяа олон хүүхэдтэй эхчүүдэд гэрийн нөхцөлд тохирсон аливаа хэлбэрийн ажил үйл эрхлэх боломж олгоход анхаарна.

86. Улс төр, эдийн засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлнэ.

Д. Ахмадуудын талаар:

87. Ахмадууд улс орныхоо хөгжил дэвшилд оруулсан хувь нэмрийнхээ үр шимийг нийгмээс хүртэх, оюун санаа амьдралын хэрэгцээгээ хангах, нийгэм, эдийн засгийн баталгаатай байх нөхцөлийг бүрдүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалахад төрийн бодлого чиглэнэ.

88. Ахмадуудын амьжиргааны баталгааг хангах, эмчилгээ сувилгаа, соёл ахуйн үйлчилгээ үзүүлэх, дэд бүтэц, мэргэжлийн ал-

быг хөгжүүлж, тэдэнд нийгмийн үйлчилгээний зохих хөнгөлөлт үзүүлэх хүрээг өргөжүүлнэ.

89. Ахмадууд ажил, амьдралын баялаг туршлага, үндэсний уламжлалаа залуу үеийнхэнд өвлүүлэх, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах, идэвхтэй амьдрах үүсгэл саначилгыг дэмжих, ахмад үеийнхний хөдөлмөр, гавьяа зүтгэлийн үнэлгээг оновчтой болгох бодлого баримтална.

90. Өвөг, дээдсээ үр ач, өргөн олон нь хайрлан хүндэтгэдэг монгол улмажлалаа үеэс үед өвлүүлэх, ахмад залуу өсвөр үеийн залгамж холбоог бэхжүүлэхийг эрхэмлэнэ.

91. Өндөр настныг гэр бүл, ураг төрлийн хүрээнд халамжлах чиглэлд түлхүү анхаарах, асрамжлах тэтгэх хүнгүй, ганц бие, биеэ дааж амьдрах чадвар мөхөс өндөр настныг орон нутагт нь асрамжлах чиглэл баримтлах, эрх зүйн баталгааг бүрдүүлнэ.

92. Тэтгэвэрт гарсан ахмад настны арвин баялаг нөөцийг зохистой ашиглах удирдлага, үйл ажиллагааны өвөрмөц тогтолцоог бий болгоно.

Е. Тахир дутуу хүний талаар:

93. Тахир дутуу хүний нийгмийн амьдралд оролцох нөхцөлийг бүрдүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, ажил үйлчилгээ эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан ажлын байр бий болгох, хөдөлмөр эрхлэлтэнд олон улсын хөдөлмөрийн стандартныг мөрдлөг болгох үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.

94. Нийгмийн хөгжлийн онцлог, шаардлагатай уялдуулан тахир дутуу хүмүүст олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж болон нийгмийн халамжийн тогтолцоог боловсронгуй болгоно.

95. Тахир дутуу, эмгэг согогтой болж байгаа шалтгааныг судлах, хүн амын амьдрах, хөдөлмөрлөх нөхцөлийн аюулгүй байдлыг хангахад тавих мэргэжлийн хяналтыг сайжруулна.

96. Тахир дутуу, эмгэг согогтой хүмүүс боловсрол эзэмших боломжийг өргөтгөх, хараагүй, дүлий, оюун ухааны хомсдолтой хүүхдэд боловсрол олгох зохистой хэлбэрийг бүх талаар дэмжинэ.

97. Тахир дутуу, эмгэг согогтой хүмүүсийн бие эрхтэн, оюуны үйл ажиллагааг нөхөн сэргээхэд гэр бүл, ойр дотны хүмүүс, олон нийтийн хүчинд тулгуурлах, төрөлжсөн эмчилгээ, сувилгааг хөгжүүлэх арга хэлбэрийг зохистой хослуулах чиглэл баримтална.

98. Тахир дутуу, эмгэг согогтой хүмүүс авьяас, чадвараа хөгжүүлэх, нийгэм, соёл, спортын арга хэмжээнд оролцох, мэдээлэл авах боломжийг өргөтгөнө.

99. Бие даан амьдрах чадваргүй, хууль ёсны асран хамгаалагч,

харгалзан дэмжигчгүй тахир дутуу хүмүүсийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулна.

ЕС. Хүн амын бодлогын удирлага, нөөцийн талаар:

100. Монгол улсын төрийн захиргааны байгууллага, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь хүн амын бодлогыг Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцүүлэн баяжуулж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

101. Хүн амын бодлогыг хэрэгжүүлж, хяналт тавих үндэсний тогтолцоог боловсронгуй болгож бэхжүүлнэ.

102. Хүн амын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, засаг болон төрийн бус байгууллагууд, иргэдийн идэвхтэй оролцоо, санаачилга, үйл ажиллагааг дэмжинэ.

103. Төрийн захиргааны бүх шатны байгууллагын ажилтнуудын хүн ам, хөгжлийн талаархи мэдээллийн хангамж, мэдлэг боловсролыг байнга дээшлүүлэхийг чухалчлан үзнэ.

104. Төрийн захиргааны бүх шатны удирдлага нь үйл ажиллагаагаа хүн амын гүнд төвлөрүүлж, тэдэнд өөрсдийн хөдөлмөр зүтгэлээр ажиллаж амьдрах арга ухааны дадал заншлыг эзэмшүүлэх замаар хүн хүчний нөөцийг хөгжүүлэх, түүнийг зохистой ашиглах нөхцөл бүрдүүлэхийг эн тэргүүнд анхаарна.

105. Хүн ам, хөгжлийн салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх нь гадаад харилцааны нэг чухал чиглэл гэж үзнэ. Хүний хөгжил, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн сайн сайхан байдлыг хангах чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 4 дүгээр
сарын 26-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн
тухай

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тухай Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 01 тоот дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасан "цуглааныг зохион байгуулагч нь бага насны хүүхдийг цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ", мөн хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан "цуглаанд оролцогч бага насны хүүхэд дагуулж явахгүй байх үүрэг хүлээнэ" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 10 дугаар зүйл, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалт, Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна." гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

Зарим сумдын нутаг дэвсгэрийн
хилийн цэсийг өөрчлөх тухай

Монгол улсын Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Тайшир, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг хавсралтын бсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 75 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтын 69 дэх хэсэг, "БНМАУ-ын хотуудын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг батлах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 252 дугаар зарлигийн 2 дугаар зүйлийн "Алтай", "Даланзадгад" гэсэн хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
1996 оны 25 дугаар тогтоолын
хавсралт

1. Есөнбулаг

Рашаантын билчирээс 4,0 км, /Урд шарын голоор уруудаж/, 2090,0 тоот, Цагаан сайрын нуруу /2498.6/, Хайчингийн булаг, Сүхийн шанд, Улаан шороо /2038.0/, Цахир толгойн бэлийн 2005.0 тоот, Илийн улаан естийн ам /2027.0/. Олон нуур /2202.0/, 2367,5 тоот, Жонгийн нурууны 3064.0, 2991.0 3025.0 тоотууд, Бидэрьяагийн билчир, 2461,0, 2470,0 тоотууд, Үет уул /2602.0/. Баянбуурлын овоо /3044.9/, 3041.3 тоот, Хангийн гол уруудаж, хилийн харуул /1890.0/, Хавтгайн явар, Ямаатын усны хөндий, Ембуу толгойн ар, Хацавчийн ам /2135.0/, Хужиртын дэнж, Дөгийн даваа /2745.0/. Хамар даваа, 3008,0 тоот, Баян-Өндөр /2541.0/, Хамар даваа /1842.0/, Енгүмэн уул /1483.7/. Хонгор толгой, Таван толгой /1206.7/, Зунгийн мод /1315.0/. Талын овоо /газар дундын овоо/, Цагаан толгой /1680.7/, Урд шарын голын ам, Рашаантын билчирээс 4,0 км.

2. Тайшир

Зост өндөр уул /3311.0/, Жинс уул /3016.0/, Бурхант уул /2464.0/, Загастайн сайрын 1594.0 тоот, Ямаат уул /2329.3/. Дулаан хар уул /2419.0/, Хараат /2262.0/, Хүүшийн цагаан толгой, Цагаан толгойн худаг /1895.0/, Ихрийн сайрын 1827.0, Сүүл толгой, Дөрвөлжин цахир /1883.0/, Зараа толгойн арын машин замын 1758.0 тоот, Зараа толгой /1865.0/, Их улаан уул /1991.0/, Бага улааны зүүн үзүүрийн овоо, Хүрдэтийн худаг, Бидэрьяагийн билчир, Жонгийн нурууны 3025.0, 2991.0, 3064,0 тоотууд, 2367,5 тоот, Олон нуур /2202.0/, Илийн улаан естийн ам /2027.0/, Цахир толгойн бэлийн 2005.0 тоот, Улаан шороо /2038.0/. Сүхийн шанд, Хайчингийн булаг, Цагаан сайрын нуруу /2498,6/, 2090,0 тоот. Рашаантын билчирээс 4,0 км /Урд шарын голыг уруудаж/, Рашаантын билчир /2103,0/, Хуурай сайрын эх /3137,3/, Зост өндөр уул /3311,0/.

3. Даланзалгэд

Улаан худаг, Өргөн цагааны бууц, Хөдөө хөвийн худаг, Бага цагаан толгой, Хөтөл усны худаг, хөх толгойн үзүүрийн бууц, Хөх голгой, Ташгайн худаг, Сэтэрхийн бууц, Талын хороотын бууц, Сайжрахын бууц, Улаан худаг.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1996 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

Эрчим хүчний тухай хууль батлагдсантай
холбогдуулан авах зарим арга хэмжээний
тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эрчим хүчний тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/ Засгийн газар, яам, тусгай газрын шийдвэрийг Эрчим хүчний тухай хуульд нийцүүлэх;

2/ Эрчим хүчний тухай хуульд заасан дүрэм, журмыг баталж мөрдүүлэх;

3/ Эрчим хүчний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг дагаж мөрдөхтэй холбогдуулан эрчим хүчний салбарын бүтцийн болон эрчим хүчний үйлдвэр, цахилгаан, дулааны станцуудын технологийн өөрчлөлт хийх арга хэмжээг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

4/ Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг дагаж мөрдөхтэй холбогдуулан хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах талаар болон бэлтгэл бусад арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.

Дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар
хот

**Ч. Загиржавт Монгол Улсын гавьяат
жүжигчин цол олгох тухай**

Дуулах ур ухааныг чадамгай эзэмшиж ардын болон зохиолын дуугаар урын сангаа байнга баяжуулж, томоохон дуулалт жүжгүүдийн гол дүрүүдэд амжилттай тоглоон үзэгч түмний талархал хүлээж соёл урлагийг хөгжүүлэхэд гарамгай хувь нэмэр оруулж байгааг нь үнэлж Увс аймгийн Хөгжимт жүжгийн хүрээлэнгийн гоцлол дуучин Чулууны Загиржавт Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар
хот

**С. Мягаунид Монгол Улсын Соёлын
гавьяат зүтгэлтэн цол олгох
тухай**

Уншигч олны талархал хүлээсэн олон арван тууж, өгүүлдэг бичиж туурвихын зэрэгцээ "Нууц товчоо", "Чингисийн эр хоёр загал", "Гологдсон хүүхэн" зэрэг монголын уран зохиолын тулгуур бүтээлүүдийг казах хэлэнд, казах хэл дээр бичигдсэн шилдэг бүтээлүүдээс монгол хэлэнд орчуулан нийтийн хүртээл болгож манай оронд утга зохиолыг хөгжүүлэхэд оруулж байгаа гарамгай хувь нэмрийг нь үнэлж, зохиолч, орчуулагч Султаниягийн-Магаунид Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 4 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

**Ү. Маамд Монгол Улсын гавьяат
багш цол олгох тухай**

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан математик, мэдээлэл зүй, физикийн гүнзгийрүүлсэн буюу төрөлжсөн сургалтыг зохион байгуулж, хүүхдийн авьяас, сонирхлыг багаас нь нээн илрүүлж хөгжүүлэх, математикийн олимпиадад шавь нараа бэлтгэж оролцуулах, залуу багш нарыг дагалдуулан сургах, гүнзгийрүүлсэн сургалтад зориулан гарын авлага, ном, товхимол туурвихад оруулсан хувь нэмрийг нь үнэлж нийслэлийн физик, математикийн сургалттай 11 дүгээр сургуулийн хичээлийн эрхлэгч Үнэнбилэгийн Маамд Монгол Улсын гавьяат багш цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 4 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

**Д. Алтангэрэлд Монгол Улсын гавьяат
хуульч цол олгох тухай**

Шүүхийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж хэрэг маргааныг мэргэжлийн өндөр түвшинд хянаж шийдвэрлэн иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл хэрэгт шударга ёс, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хэрэгжүүлэн төрийн хууль тогтоомжийг сурталчлах, хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх, олон арван хуульч, шүүгчдийг сургаж дадлагажуулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Улсын Дээд шүүхийн шүүгч Даниагийн Алтангэрэлд Монгол Улсын гавьяат хуульч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 5 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

**Равдангийн Хатанбаатарыг элчин
сайдвар томилох тухай**

Равдангийн Хатанбаатарыг Монгол Улсаас Бүгд Найрамдах
Австри Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдвар
томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 5 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 87

Улаанбаатар
хот

**Албан тушаалын зэрэг дэв
олгох тухай**

1. Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь
хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын санал
болгосноор хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад
тэргүүн түшмэлийн албан тушаалын холбогдох зэрэг дэв олгосугай.

2. Энэ зарлигийг 1996 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн
мөрдөхөөр тогтоосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
1996 оны 87-р зарлигийн хавсралт

**ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ
ДЭВ ОЛГОСОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН
ХААГЧДЫН ЖАГСААЛТ**

№	Овог нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрэгтэй	Албан тушаалын зэрэг дэв
1.	Зундуйн Саарал	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга	АА-1	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл
2.	Намжилдоогийн Чадраабал	Төрийн захиргааны албаны зөвлөлийн гишүүн	ТЗ-12	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл
3.	Дансрангийн Мужаан	Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны дарга	АА-3	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл
4.	Гарьдын Дагва	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	АА-3	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл
5.	Сүрэнгийн Хажидсүрэн	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	АА-3	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл
6.	Дамдинсүрэнгийн Бямбаа	Улаанбаатар хотын ерөнхий менежер	ТЗ-13	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл
7.	Бадрахын Шаравсамбуу	Улсын гаалийн ерөнхий газрын дарга	ТЗ-13	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл
8.	Лханаасүрэнгийн Пүрэвдорж	Улсын татварын ерөнхий газрын дарга	ТЗ-13	Тэргүүн зэрэг тэргүүн түшмэл

9.	Ядамсүрэн- гийн Яндаг	Төр, Засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дарга	T3-12	Тэргүүн зэрэг тэргүүн гүшмэл
10.	Ламжавын Лингов	Төрийн захиргаа- ны албаны зөвлө- лийн дарга	TӨ-ҮА	Дэд зэрэг тэргүүн- гүшмэл
11.	Цэрэнбал- жирын Самбаллхүндэв	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	AA-3	Дэд зэрэг тэргүүн гүшмэл
12.	Лувсанбатын Нороврэнчин	Шүүхийн Тамгын газрын дэд дарга	AA-1	Дэд зэрэг тэргүүн гүшмэл
13.	Магсарын Лангав	Улсын Их Хур- лын Тамгын газрын хэлтсийн дарга	AA-2	Дэд зэрэг тэргүүн гүшмэл
14.	Лхагваагийн Дэмбэрэл	Үндэсний хөгж- лийн газрын дэд дарга	T3-13	Дэд зэрэг тэргүүн гүшмэл
15.	Тугалхүүгийн Баасансүрэн	МОНЦАМЭ агентлагийн дэд дарга	T3-12	Дэд зэрэг тэргүүн гүшмэл
16.	Цэндийн Альяа	Төрийн захиргаа, удирдлагын хөгж- лийн институ- тийн захирал	T3-12	Дэд зэрэг тэргүүн гүшмэл
17.	Жавчигийн Сэрээтэр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга	AA-1	Гутгаар зэрэг тэргүүн гүшмэл
18.	Чулууны Отгонбаяр	Улсын Их Хур- лын Тамгын газ- рын боловсон хүчний эрхлэгч	AA-2	Гутгаар зэрэг тэргүүн гүшмэл
19.	Чулууны Батжаргал	Төрийн ёслолын албаны дарга	AA-3	Гутгаар зэрэг тэргүүн гүшмэл

20.	Цэрэнбалжирын Бүжинтхам	Дээд шүүхийн судалгааны төвийн захирал	АА-3	Гутгаар зэрэг тэргүүн түшмэл
21.	Пүрэвдоржийн Ганбаатар	Нийслэлийн Засаг даргын орлогч	ТЗ-13	Дөтгөөр зэрэг тэргүүн түшмэл
22.	Цэрэндоогийн Мөнхтөр	Монголын радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дэд дарга	ТЗ-12	Дөтгөөр зэрэг тэргүүн түшмэл

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1996 оны 4 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

**Улсын Их хурлын сонгуулийн хуульд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим
залт Үндсэн хууль зөрчсөн эсэх
тухай маргааны талаар**

Энэ дүгнэлтийг 1996 оны 4 дүгээр сарын 10-ны 14 цагт Төрийн ордны 251 дүгээр тасалгаанд үйлдэв. Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн дарга Г. Совд даргалж, гишүүдэд Л. Баасан, Ц. Цолмон, Н. Жанцан /илтгэгч/, Ж. Бямбажав нарын бүрэлдэхүүнтэй Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б. Цэндээхүүг оролцуулан хийв.

Хуралдаанд маргагч талуудыг төлөөлж гомдол гаргач иргэн Ц. Цэрэнжээ, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б. Ганболд, Ц. Шаравдорж нар оролцов.

Иргэн Ц. Цэрэнжээ Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна. Аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн

сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийг мөн хуулийн арванзургадугаар зүйлийн 9 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Учир нь манай улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдах бөгөөд хүн бүр өөрийн оршин суугаа газрынхаа төрийн байгууллагуудад шууд болон төлөөллийн аргаар хандаж, төр нийгмийн хэргийг удирдахад оролцох өргөн боломжтой байдаг.

Нөгөө талаас бүх иргэн эрхээ хэрэгжүүлэх ижил эрх тэгш боломжоор хангагдсан байх эрхтэй. Дээрх нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн заалт нь агуулгын хувьд энэхүү эрхтэй зөрчилдөж байна.

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 2/21 дүгээр зүйлийн 5 дахь заалтад "Улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлдээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтыг зөрчсөн байна" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б. Ганболд, Ц. Шаравдорж нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

Улсын Их Хурлын гишүүн нь тодорхой нэг тойргоос сонгогдож, улмаар зөвхөн тэр л тойргийнхоо хүмүүсийн санаа бодлыг илэрхийлж, тэр л сум, аймгийнхаа нийгэм, эдийн засаг, соёл, Улс ардын аж ахуйн том жижиг асуудлыг хөөцөлдөж Ардын Их Хурлын чуулганд очиж хуралдаж байсан урьдын депутат бишээ. Улсын Их Хурлын гишүүн нь хууль тогтоох эрх мэдлийг хадгалсан төрийн эрх барих дээд байгууллагад нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмтэн баримталж, сонгуулийн хугацаандаа байнга ажилладаг ард түмний элч юм.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын гишүүн нь тодорхой тойргоос сонгогдох боловч түүний үйл ажиллагаа нь Улсын хэмжээнд гэдгийг мартаж болохгүй. Иймд аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын Сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно" гэсэн заалт нь иргэдийн эрхээ хэрэгжүүлэх ижил тэгш боломжийг хаан боогдуулж байгаа явдал биш бөгөөд хууль тогтоох цэцэд байгууллагаа сонгох, төрийн хэрэгт оролцоход нь ялгаатай ихцэлийг үүсгээгүй, тэдний хүсэл сонирхлыг хүчээр хаан боогдуулсан явдал бишээ.

Монгол Улсын засаг захиргааны нэгжийн байгуулагдах, өөрчлөгдөх зарчим, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэд өөрийн

сум, аймгийн төрийн байгууллагатай харьцах харилцааны асуудлыг Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах зарчимтай хольж хутган ойлгох ёсгүй.

Нөгөө талаар Улсын Бага Хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль"-ийн 6 дугаар зүйлийн 2-т "Аймагтай адилтгах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг хэрэв Улсын Их Хурлын гишүүний нэг мандатад ногдох улсын дунджаас цөөн хүн амтай бол зэргэлдээ аймагтай нь нэгэн тойрог болгоно" гэсэн заалт байгаа бөгөөд энэ заалтыг л агуулгын хувьд баяжуулж улам боловсронгуй болгоход анхаарч нэмэлт, өөрчлөлт хийсэн болохоос биш Улсын Их Хурал цоо шинээр заалт хийгээгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Дээрх заалттай хуулийг удирдлага болгон 1992 оны сонгууль амжилттай явагдаж сонгууль нь монголын сонгуулийн эрх бүхий нийт иргэдийн сонгох эрхийг бүх талаар хангасан ардчилсан байдлаар болж өнгөрлөө гэсэн дүгнэлтийг гадаад орнуудын хэвлэлд хийж, уригдан ирсэн гадаадын ажиглагчид санал нэгтэй байсныг бид мартаж учиргүй.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн заалт агуулгын хувьд иргэдийн сонгох эрхтэй зөрчилдөөгүй гэдгийг хэлэх байна.

2. Олон улсын сэтгүүлчдийн практик ажиллагааг харахад аливаа дангаар ноёрхлыг арилгаж нийгэм дэх олон үзэл бодлыг аль болох өргөн тусгасан сонин хэвлэл бололцооны хирээр гаргах зарчим баримталдаг.

Нөгөө талаар чөлөөт хэвлэл нэг талыг баримтлахаас үргэлж зайлсхийдэг жамтай. Энэ бүгдээс үзэхэд Улсын Их Хурлаас баталсан хуулийн заалт нь олон улсын сэтгүүлчдийн тавьдаг ерөнхий шаардлагатай нийцэж байна.

Чухамдаа аливаа хэвлэл нэг талыг барих асуудлаас зайлсхийснээр нэр дэвшигч болон сонгогчид аль болох олон радио, телевиз, сонин хэвлэлд хандах боломжийг нээж байна.

Төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгсэлд дангаар сурталчилгааг хориглосноор бүх төрлийн хэвлэлд нэр дэвшигчдийг адил тэгш сурталчлах бололцоог нээж байгаа юм гэжээ.

Иргэн Ц. Цэрэнжээ Цэцийн хуралдаанд оролцож тивьсан тайлбартаа:

Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн заалт нь зөвхөн сонгуулийн насны хүний тоог өрөөсгөлөөр гол шалгуур болгосон байна.

Нэгэн нутагт оршин буй иргэдэд хууль тогтоох дээд байгууллагаа сонгох, төрийн хэрэгт оролцоход нь ялгаатай нөхцөл үүсгэж, тэдний хүсэл сонирхлыг хүчээр хаан боогдуулж өөр орон нутагт нэр дэвшигчийн төлөө санал өгөхийг шаардахад хүрч байна. Үүний сөрөг үр дагавар их бөгөөд сонгууль чөлөөтэй байх үндсэн хуулийн заалтыг ч зөрчиж байна.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хэлээд байгаа шиг сонгуулийн нутаг дэвсгэр гэсэн ойлголт Монгол Улсын хууль тогтоомжид байхгүй.

Төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд дагнасан сурталчилгаа хийхийг хориглож болох юм. Харин хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хааж боох нь тэдний улс төрийн болон бусад эрх чөлөөг илтэд хаахад хүрч байна гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Шаравдорж Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож хэлсэн үгэндээ: Монгол Улсын Үндсэн хуулинд Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана гэж заасан, мөн үндсэн хуульд Монгол улс Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна гэж заасан, эдгээр заалтууд хоорондоо нягт уялдаатайгаас гадна бие даасан үгтэй илэрхийлж байгааг зөв ойлгох ёстой. Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс энэ нь сонгуулийн тойргийг заавал засаг захиргааны нэгжид хатуу зохицуулна гэж ойлгож болохгүй.

Засаг захиргааны нутаг дэвсгэр гэдгийг сонгуулийн нутаг дэвсгэр гэсэн ойлголттой хольж хутгаж болохгүй гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б. Ганболд Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож хэлсэн үгэндээ: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэдийгээр хувийн өмч байлаа ч тэр нь олон нийтийн дуу хоолой байх ёстой. Хэний ч бичсэн юмыг хэвлэн нийтэлж байж уг хэвлэл чөлөөт хэвлэлийн шинжээ хадгалах ёстой. Тэгэхгүйгээр дагнасан сурталчилгаа хийгээд байвал чөлөөт хэвлэлийн зарчмыг алдагдуулж байгаа юм.

Дагнасан гэдэг нь хоёр буюу түүнээс дээш гэсэн ойлголт. Дагнасан сурталчилгаа нь тэгш биш байдлыг бий болгож байна. Гэнцүү сурталчилгаа хийгдсэнээс олон түмэн зөв сонголт хийх, бие даасан нэр дэвшигчид эрх чөлөөгөө эдлэх боломж нээгдэнэ гэжээ.

Хянавал:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, эрчлэлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог саргалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна. Аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн

сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно" гэсэн заалт сонгуулийн тойрог бүрт сонгогчдын тоо харьцангуй тэнцүү байх нийтлэг зарчимд харшлагагүй бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдах нөхцөлийг алдагдуулсан, сонгогчдын хүсэл сонирхлыг хүчээр хаан боогдуулсан, сонгуульд оролцоход нь ялгаатай нөхцөл үүсгэсэн гэх үндэслэлгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2/21 дүгээр зүйлийн 5 дахь заалт "Улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин сэтгүүдээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэн заалт нь сонгуульд өрсөлдөгчийн адил тэгш нөхцөлийг хангахад чиглэгдсэн бөгөөд хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарласан гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иймд энэ талаар гаргасан иргэн Ц. Цэрэнжээгийн хүсэлтийг хангах үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон дүгнэлт гаргах нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1/8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Сонгуулийн тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоог харгалзан санал авах өдрөөс 70 хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулна. Аймгийн хүн амын тоо нь Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумуудтай нэгтгэн нэг тойрог байгуулж болно" гэсэн заалт, мөн хуулийн нэгдүгээр зүйлийн 2/21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

2. Цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж хэрхэн шийдвэрлэсэн тухай харну ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилъя.

Дарга

Г. СОВД

Гишүүд

Л.БААСАН
Н.ЖАНЦАН
Ц.ЦОЛМОН
Ж.БЯМБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар
хот

Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай

"Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сайд, тусгай газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а) иргэдээс яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллагад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч хэрхэн шийдвэрлэх журмыг тус тусын чиглэлээр боловсруулан баталж мөрдүүлсүгэй;

б) иргэдээс яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллагад гаргасан өргөдөл, гомдлын тойм, шийдвэрлэлтийн байдал, мөрөөр нь зохиосон ажил, тэдгээрт туссан асуудлуудаас өөрийн байгууллагын явуулах бодлого, авах арга хэмжээнд хэрхэн тусгаж хэрэгжүүлсэн болон шийдвэрлүүлж харну өгүүлэхээр Засгийн газраас шилжүүлсэн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээллийг хагас, бүтэн жил (хагас жилийнхийг 7 дугаар сарын 15-ны, жилийн эцсийнхийг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор)-ээр гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байсугай.

2. "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж удирдах үүргийг хүлээж дор дурдсан зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (С.БАНЗРАГЧ)-т үүрэг болгосугай:

а) иргэдийн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтныг арга зүйн удирдлагаар хангах, сургалт семинар, ярилцлага зохион байгуулах, өргөдөл, гомдлын мөрөөр зохиож байгаа ажлын арга туршлагыг судалж дэлгэрүүлэх, байгууллага, иргэдэд зөвлөлтгөө өгөх;

б) "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас зохиож байгаа ажил, түүний үр дүнтэй танилцаж, ажилд нь туслалцаа үзүүлэх;

в) иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудад хандаж гаргасан өргөдөл, гомдлын тойм, шийдвэрлэсэн байдал, түүнд хөндсөн асуудлууд, тэдгээрийг төрийн захиргааны тухайн байгууллагаас явуулах бодлого, авах арга хэмжээнд хэрхэн тусгасан тухай мэдээллийг нэгтгэн, дүгнэлт хийж яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт жилд 2 удаа мэдээлж байх;

г) иргэдээс Засгийн газарт хандаж гаргасан зарим өргөдөл, гомдлоос Засгийн газрын гишүүний үйл ажиллагааны хүрээнд хамаарах асуудлыг Засгийн газрын тухайн асуудал хариуцсан гишүүнд, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хамаарах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт шилжүүлэн шийдвэрлүүлж хариу өгүүлэх, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж байгаад хяналт тавьж дүнг сар, улирал, жилээр нэгтгэн гаргаж байх;

д) иргэдийг хүсэлтээр нь Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдтэй уулзуулах ажлыг зохион байгуулж, тэдэнд тавьсан асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай нэгдсэн мэдээг сар, улирлаар гаргах;

е) иргэдээс гаргасан өргөдөл, гомдолд дурдсан Засгийн газраас явуулж байгаа бодлого, шийдвэрийн талаархи санал бодлыг холбогдох эрдэм шинжилгээ, судалгааны болон бусад байгууллагуудтай хамтран судалж, дүгнэлт хийх үндсэн дээр холбогдох арга хэмжээ авахуулах;

ж) Засгийн газарт болон төрийн захиргааны байгууллагуудад иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын агуулга, бүтцэд судалгаа хийж, нийтлэг ач холбогдолтой санал, хүсэлт, ажил хэрэгч шүүмжлэлтүүдийг нэгтгэн төр, засгийн бодлого, шийдвэрт тусгуулах болон төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас анхаарч, цаашид явуулах бодлого, авах арга хэмжээнд нь тусгуулах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сар тутам мэдээлж, улиралд нэг удаа Засгийн газрын хуралдаанд танилцуулж байх.

3. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хамаарах асуудлаар иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг тухайн буюу дээд шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шилжүүлэн шийдвэрлүүлж, дүнг нэгтгэн энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлийн "б", 2 дугаар зүйлийн "г"-д заасан сар, улирал, жилийн мэдээлэлд

оруулж байхыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд

Л. ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар
хот

**Хөтөлбөр хэрэгжүүлэх талаар
авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын 1995 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах комиссыг хавсралтад дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах комисс, сайд, тусгай газрын дарга, бүх шатны Засаг дарга нарт даалгах нь:

а/ яам, тусгай газар, аймаг, нийслэл, сум, дүүрэг, байгууллага, аж ахуйн нэгж бүрт монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг 1995 оноос эхлэн төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсугай;

б/ монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийнхээ төсөвт тусгаж байсугай;

в/ оршин суугаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон ажил хөдөлмөр эрхэлдэг байгууллагынх нь шугамаар иргэдийг монгол бичигт сургах ажлыг 1996 оноос эхлэн тэдний монгол бичгийн талаархи мэдлэгийн түвшинтэй уялдуулан зохион байгуулсугай;

г/ төрийн байгууллагаас гаргасан шийдвэр, бусад баримт бичиг, зар сурталчилгаа, реклам чимэглэл зэргийг монгол бичгээр хэвлэн нийтлэх, хийх замаар монгол бичигт иргэдийг сургах орчныг бүрдүүлэх арга хэмжээг авч байсугай;

д/ 16-45 насны иргэдийн монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох үзлэгийг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, байдлыг шалгаж танилцах ажилтай хамт яам, тусгай газар, нийслэл, аймгуудад 1996 онд багтаан явуулсугай.

3. Дайчдыг цэргийн алба хаах хугацаанд нь монгол бичигт сургах ажлыг 1996 оноос эхлэн зохион байгуулахыг Батлан хамгаалах яам /Ш. ЖАДАМБАА/, Хилийн цэргийг удирдах газар /П. СҮНДЭВ/, Цагдаагийн ерөнхий газар /Б. ПҮРЭВ/-т даалгасугай.

4. Монгол бичгээр хэвлэгддэг сонин, хэвлэлийн тоог нэмэгдүүлэх, хэвлэлтийн чанарыг сайжруулах, бусад сонин, хэвлэлд монгол бичгийн нүүр, булан, хавсралт гаргах, монгол бичгээр ном хэвлэх ажлыг өргөтгөх арга хэмжээ авахыг Соёлын яам /Н. ЭНХБАЯР/-д даалгасугай.

5. Монгол бичгээр ном, сонин, сэтгүүл, сурах бичиг, гарын авлага хэвлэхэд шаардагдах техник, технологийн нөхцөлийг бүрдүүлэх саналыг хөрөнгийн тооцооны хамт боловсруулж 1996 оны 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Үндэсний хөгжлийн газар /Ч.УЛААН/, Соёлын яам /Н.ЭНХБАЯР/, Сангийн яам /Э.БЯМБАЖАВ/-д даалгасугай.

6. Төв, орон нутгийн хэвлэх үйлдвэрүүдийг монгол бичгээр ном, сурах бичиг, сонин хэвлэх чиглэлээр шинэчлэн тоноглох, тэдгээрийн хүч чадлыг нэмэгдүүлэх, хэвлэлийн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах арга хэмжээг 1996 оноос дэс дараатайгаар авч хэрэгжүүлэхийг Соёлын яам /Н. ЭНХБАЯР/, Шинжлэх ухаан, боловсролын яам /С. ТӨМӨР-ОЧИР/-д даалгасугай.

7. Иргэдийг монгол бичигт үе шаттайгаар сургах хөтөлбөр, тэдэнд зориулсан ном, сурах бичиг, гарын авлага боловсруулан гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр монгол бичгийн сургалтыг байнга явуулах, монгол бичгийн талаар сургалчлах арга хэмжээ авахыг Шинжлэх ухаан, боловсролын яам /С.ТӨМӨР-ОЧИР/, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар /Ө.ЭНХТҮВШИН/-т даалгасугай.

8. Шинжлэх ухаан, боловсролын яам /С.ТӨМӨР-ОЧИР/-д даалгах нь:

а/ бүх шатны сургуулийн монгол бичгийн хичээлийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн баталж, 1995/1996 оны хичээлийн жилээс эхлэн мөрдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авсугай;

б/ бүх шатны сургуулийн багш нарыг монгол бичигт үе шаттайгаар сургах ажлыг 1996 оноос эхлэн зохион байгуулсугай;

в/ оюутан, сурагчдад зориулсан уран зохиолын болон шинжлэх ухааны ном, зохиолыг монгол бичгээр хэвлэн нийтлэх ажлыг өргөтгөх, ерөнхий боловсролын сургуулийн монгол бичгээр сургавал

зохиx хичээлийн сурах бичиг, гарын авлагыг тогтоосон хугацаанд нь хэвтүүлэх арга хэмжээ авч байсугай;

г/ монгол бичиг заадаг багш нарыг зохиx журмын дагуу урамшуулж байхын зэрэгцээ тэднийг иргэдийг монгол бичигт сургах ажилд зохион байгуулалттайгаар татан оролцуулж байсугай.

9. Монгол бичгийг стандартчилж тогтсон хэв загвартай болгох асуудлыг шинжлэх ухаан, технологийн болон олон талын хамтын ажиллагааны төслийн хэлбэрээр 1997 онд багтаан боловсруулж шийдвэртэхийг Үндэсний хөгжлийн газар /Ч.УЛААН/, Шинжлэх ухаан, боловсролын яам /С.ТӨМӨР-ОЧИР/-д даалгасугай.

10. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиож байгаа ажлын явц, байдлыг улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж Засгийн газарт хагас жил тутам танилцуулж байхыг Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах комисст даалгасугай.

11. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Бүх нийтээр монгол бичигт суралцах ажлыг зохион байгуулах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 285 дугаар тогтоол, "БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл хангах тухай" Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 186 дугаар тогтоол, "Албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 1992 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 63 дугаар тогтоол, "Албан хэргийг монгол бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Шинжлэх ухаан, боловсролын сайд

С. ТӨМӨР-ОЧИР

Засгийн газрын 1995 оны 223
дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

- Комиссын дарга - Шинжлэх ухаан, боловсролын сайд
- Гишүүд:
- Соёлын сайд;
 - Гадаад харилцааны сайд;
 - Хууль зүйн сайд;
 - Батлан хамгаалахын сайд;
 - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
 - Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга;
 - Сангийн дэд сайд;
 - Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлагийн дэд захирал;
 - "Засгийн газрын мэдээ" сонинны эрхлэгч;
 - Улсын архивын хэрэг эрхлэх газрын дарга;
 - Шинжлэх ухаан, боловсролын яамны Ерөнхий боловсролын газрын дарга;
 - Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал;
 - "Монгол бичгийн төлөө" нийгэмлэгийн тэргүүн;
 - Боловсролыг дэмжих сангийн ерөнхийлөгч;
 - Монголын соёлын сангийн захирал;
 - Үндэсний монгол бичгийг сэргээх олон улсын сангийн даамал.
- Комиссын нарийн бичгийн дарга - Засгийн газрын референт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 227

Улаанбаатар
хот

Улсын хяналтын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Таримал ургамлын үрийн улсын хяналтын дүрэм"-ийг 1 дүгээр, "Ургамал хамгаалал, хорио цээрийн улсын хяналтын дүрэм"-ийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсангай холбогдуулан "Хөдөө аж ахуйн таримлын үрийн улсын байцаагчийн дүрэм батлах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1982 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 403, "Дүрэм батлах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 179 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Хүнс, хөдөө аж ахуйн сайд

Ц.ӨӨЛД

Засгийн газрын 1995 оны 227 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт.

ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Таримал ургамлын үрийн улсын хяналтын зорилго нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс таримал ургамлын үрийн аж ахуйн таллархи хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байууллагаас гаргасан журам, зааврын биелэлтийг хангуулахад оршино.

2. Улсын хяналтыг таримал ургамлын үрийн улсын хяналтын алба, аймаг, нийслэлд ажиллах улсын байцаагчид хэрэгжүүлдэг.

3. Таримал ургамлын үрийн улсын хяналтын албаны дарга нь таримал ургамлын үрийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

Таримал ургамлын үрийн хяналтын улсын ерөнхий байцаагчийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд түүнд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4.Таримал ургамлын үрийн улсын хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчдыг таримал ургамлын үрийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд томилж чөлөөлнө. Аймаг, нийслэлд ажиллах таримал ургамлын үрийн хяналтын улсын байцаагчдыг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээрт байцаагчийн эрхийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд олгоно.

5.Таримал ургамлын үрийн улсын хяналтын улсын байцаагчид нь таримал ургамлын асуудлаар мэргэшсэн байна.

6.Таримал ургамлын үрийн хяналтын алба, улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

7.Таримал ургамлын үрийн хяналтын улсын ерөнхий болон улсын ахлах байцаагч, улсын байцаагчид /цаашид энэ дүрэмд "байцаагч" гэх/ нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

8.Аймаг, нийслэлд ажиллаж байгаа байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг Таримал ургамлын үрийн улсын хяналтын алба хэрэгжүүлнэ.

Хоёр.Таримал ургамлын үрийн улсын хяналтын чиглэл

9.Таримал ургамлын үрийн улсын хяналтыг дор дурасан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/улсын сорт сорилтын салбар, үр шинжилгээ, хяналтын лабораториудын шинжилгээ, судалгааны ажлын чанар;

б/газар тариалангийн бүс бүрийн нөхцөлд хөдөө аж ахуйн таримал ургамлын сорт сорилтын ажил явуулах, чанар сайтай шилдэг сортуудын сонгон шалгаруулалт, нутагшуулалт, сорт сорилт, шинэчлэлтийн ажлын байдал;

в/байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс үйлдвэрлэсэн таримлын элит болон дээд үржүүлгийн үрэнд тарих үрийн чанарын, сорт сорилтын салбаруудаас шалгарсан таримал сортуудад технологийн бүрэн шинжилгээ хийсэн байдал;

г/эрдэм шинжилгээний байгууллагаас үйлдвэртэсэн болон импорттоор авч байгаа хөдөө аж ахуйн таримлын элит, дээд үржүүлгийн үрийг цэврээр үржүүлэх, нутагшсан сортын үрээр үйлдвэрлэлийг хангах, хөдөө аж ахуйн байгууллагуудын болон улсын үрийн нөөцөд стандартын шаардлага хангасан үр нөөцлөлт, нийлүүлэлт;

д/хөдөө аж ахуйн таримал ургамлын сортын тариалангийн хянан баталгаажуулалт, тарих үрийн нөөцлөлт, цэвэрлэгээ, дугаарлалт, хадгалалтын чанар;

е/тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тариалах үрийн бэлтгэл, чанар, хадгалалт, хамгаалалт, хуваарилалт, тайлан мэдээ, анхан шатны бүртгэл, баримт бичгийн хөгжлөлт;

ж/хөдөө аж ахуйн таримлын үр, суулгачын экспорт, импорт, з/тариалангийн үйлдвэртэл эрхлэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үрийн аж ахуй эрхэлж байгаа байдал.

Гурав.Таримал ургамлын үрийн хяналтын байшаагчийн үүрэг, эрх

10.Байшаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/энэ дүрмийн 9 дүгээр зүйлд заасан чиглэлийн дагуу улсын хяналтыг зохион байгуулж явуулах;

б/олон улсын эрх бүхий байгууллагаас баталж улс бүрт нийтлэг мөрдөж байгаа үр, үрийн материалын холбогдолтой конвенци, эрх зүйн бусад актууд Монгол улсын нутаг дэвсгэр дээр хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих;

в/хяналт шалгалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгжийн үйлдвэртэл, технологийн нууцыг чанд хадгалах;

г/хууль тогтоомжийг чанд сахиж, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

д/хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлага, тоо баримтын үндэстэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн харуулах.

11.Байшаагч дор дурдсан эрх эзэлнэ:

а/улсаас баталгаажуулаагүй чанар муутай үрээр тариалалт явуулж хохирол учруулсан, сонгон шалгаруулалтаар нутагшаагүй сортын үрийг ашигласан зэрэг нь хөдөө аж ахуйн таримлын ургацад муугаар нөлөөлөх, хүний амь нас, эрүүл мэндэд шууд буюу шууд бусаар хохирол учруулж байгаа буюу хохирол учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон тохиолдолд тухайн үйлдвэрлэлийн үйл

ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, цэвэршүүлэх, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлахгүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухайгаа олон нийтэд мэдээлэх. Энэ шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай шийдвэр гаргах;

б/тариалалт, ургац хураалтын үеийн ажлын нөхцөл болон технологийн шаардлагыг хангаагүй ажлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг ажилчин, албан хаагчдад олгохыг хориглох;

в/ноцтой аюул осол гарсан, хүний эрүүл мэнд хохирсон, учруулсан хохирол нь нийгмийн хор холбогдол ихтэй бол шалгалтын акт, материалыг хуулийн байгууллагад шилжүүлэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

г/албан үүргээ гүйцэтгэж яваа үедээ үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа ажлын байр, талбайд саадгүй нэвтрэн орох;

д/хяналт шалгалтаар илэрсэн дутагдал, зөрчлийг таслан зогсоох, түүнийг арилгах талаар байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд хугацаатай албан шаардлага, үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

е/хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

ж/байцаагч өөрийн гаргасан шийдвэрээ баталгаажуулах зорилгоор улсын үр шинжилгээний экспертизийн төв лаборатори, эрдэм шинжилгээний хүрээлэнгээр үр, суулгачын чанарыг үнэ төлбөргүй тодорхойлуулах.

12. Байцаагч нь таримал ургамлын үрийн хяналтын талаархи хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, зөрчлийг арилгуулах талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн заалтыг үндэслэн дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

а/хадлан тариалангийн талбайд мал, тэжээнэр амьтад оруулан гишгүүлж идүүлэх зэргээр таримал жимс, жимсгэнэ, үр, суулгац, тарьц устгасан, гэмтээсэн, таримлын үр, сортын чанар алдагдуулсан гэж буруутай этгээдэд 500-25000 төгрөгийн торгууль ногдуулах;

б/таримал ургамлын үрийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын байцаагч нь хяналт шалгалтаас зайлсхийсэн албан

тушаалтанд 5000-10000, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн албан тушаалтанд 15000 хүргэл төгрөгийн торгууль ногдуулах;

в/хяналт шалгалтын байгууллага, байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-25000, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон этгээдийг 35000 хүргэл, хяналт шалгалтын холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч бичиг баримт гаргаж өгсөн албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр торгуулах саналаа шүүгчид тавьж шийдвэрлүүлэх.

Дөрөв. Бусад зүйл

13.Таримал ургамлын үрийн улсын хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

14.Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно. Уг гомдлыг хүлээн авсан хяналт шалгалтын байгууллагын эрх баригч түүнийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэх арга хэмжээ авна. Хэрэв гомдол гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын байгууллагын шийдвэрийг зөвшөөрөхгүй бол гомдлоо шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахүй байх үндэслэл болохгүй.

15.Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

УРГАМАЛ ХАМГААЛАЛ ХОРИО ЦЭЭРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үнлэглэл

1. Ургамал хамгаалал хорио цээрийн улсын хяналтын зорилго нь байгууллага, аж ахуйн нэгжээс ургамал хамгаалал, хорио цээрийн талаархи хууль, тогтоомж болон эрх бүхий байгууллагаас тогтоосон захиргааны журмын биелэлтийг хангуулахад оршино.

2. Улсын хяналтыг ургамал хамгаалах алба, аймаг, нийслэлд ажиллах улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

3. Ургамал хамгаалах албаны дарга нь ургамал хамгаалал, хорио цээрийн улсын хяналтын ерөнхий байцаагч байна. Ургамал хамгаалал, хорио цээрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд түүнд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын албаны ахлах байцаагч, улсын байцаагчдыг ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын ерөнхий байцаагчийн санал болгосноор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө. Аймаг, нийслэл, гүний болон хилийн хорио цээрийн улсын байцаагчдыг аймаг, нийслэлийн засаг дарга томилж чөлөөлөх бөгөөд тэдгээрт байцаагчийн эрхийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд олгоно.

5. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагчид нь ургамал хамгаалал, хорио цээрийн асуудлаар мэргэшсэн байна.

6. Ургамал хамгаалах алба, улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

7. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын ерөнхий байцаагч болон улсын ахлах байцаагч, улсын байцаагчид /цаашид энэ дүрмэнд "байцаагч" гэх/ нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

8. Аймаг, нийслэл, хилийн болон гүний хорио цээрийн сал-
барт ажиллаж байгаа байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар
хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах,
шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж
шийдвэрлүүлэхийг ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын алба
хэрэгжүүлнэ.

**Хоёр. Ургамал хамгаалал, хорио цээрийн
улсын хяналтын чиглэл**

9. Ургамал хамгаалал, хорио цээрийн улсын хяналтыг дор
дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ургамал хамгаалал, хорио цээрийн талаар гарсан хууль тог-
тоомж болон түүнтэй нийцүүлж гаргасан дүрэм, журмын хэ-
рэгжилт;

б/ургамал хамгааллын зориулалт бүхий техник, тоног төхөө-
рөмж, бодисын ашиглалт, хэрэглээ, хадгалалт, хамгаалалтын байдал;

в/ургамал хамгаалал, хорио цээрийн талаар бусад оронтой
байгуулсан гэрээ, хэлэлцээрийн биелэлт;

г/ургамлын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, тээвэр-
лэлт, хадгалалт, боловсруулалт, борлуулалтын үеийн хорио цээ-
рийн шаардлагын биелэлт;

д/ургамлын хориотой, гоц хөнөөлт өвчин, хортон, хог ур-
гамлын хөнөөлийн голомт илэрсэн нөхцөлд тодорхой нутаг дэвс-
гэр, бүс нутагт хорио цээр тогтоох, дүгнэлт гаргах;

е/үр, ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний
зөвшөөрөл олголт;

ж/ургамал, үр, ургамлын гаралтай бусад бүтээгдэхүүн тээ-
вэрлэсэн бүх төрлийн тээврийн хэрэгслийн эрүүл ахуйн байдал;

з/мөөг, ян, хорууны өсгөвөр, амьд шавьж, ургамлын хатаа-
дас, ургамлын өвчин, хортоны цуглуулгын хорио цээрийн байдал;

и/байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эдэлбэр газар, зоорь
агуулах, түүнд байгаа бүтээгдэхүүний өвчин хортон, хог ургамлын
халдваргүй байдал.

**Гурав. Ургамал хамгаалал, хорио цээрийн хя-
налтын улсын байцаагчийн үүрэг, эрх**

10. Байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/энэ дүрмийн 9 дүгээр зүйлд заасан чиглэлийн дагуу улсын
хяналтыг зохион байгуулж явуулах;

б/олон улсын эрх бүхий байгуудлагаас баталж улс бүрт нийтлэг мөрдөж байгаа ургамал хамгаалал, хорио цээрийн холбогдолтой конвенци, эрх зүйн бусад актууд Монгол улсын нутаг дэвсгэр дээр хэрхэн хэрэгжиж байгааг шалгах;

в/хяналт шалгалт хийсэн байгуудлага, аж ахуйн нэгжийн үйлдвэртэл, технологийн нууцыг чанд хадгалах;

г/хууль тогтоомжийг чанд сахиж, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх, байгуудлага, аж ахуйн нэгж, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

д/хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлага, тоо баримтын үндэстэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах.

11. Байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/холбогдох байгуудлагатай тохиролцож зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт, шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн задлан шинжилгээг мэргэжлийн байгуудлагаар гүйцэтгүүлэх;

б/хориотой болон ургамлын онц аюултай өвчин, хортон, хог ургамал шалгалтаар илэрсэн нь цаашид хүн, мал, амьтны эрүүл ахуйд муугаар нөлөөлж хохирол, гэм хор учруулж болзошгүй байвал уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд байгуудлага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, цэвэршүүлэх, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харцлахгүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухайгаа олон нийтэд мэдээлэх. Энэ шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол тухайн үйлдвэртэлийг бүрмөсөн зогсоох шийдвэр гаргах;

в/ургамал хамгаалал, хорио цээрийн нөхцөл болон хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ариутгах, угаах бодисын технологийн шаардлага хангаагүй ажлын хувцас, бие хамгаалах хэрэгслийг ажилтан, ажилчдад олгохыг хориглох;

г/ноцтой аюул, осол гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, учруулсан хохирол нь нийгмийн хор аюул ихтэй бол шалгалтын акт, материалыг хуулийн байгуудлагад шилжүүлэх;

д/албан үүргээ гүйцэтгэж яваа үедээ үйлдвэртэл, үйлчилгээ явуулж байгаа ажлын байр, талбайд саадгүй нэвтрэн орох;

е/хяналт шалгалтаар илэрсэн дутагдал зөрчлийг таслан зогсоох, арилгах талаар байгуудлага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд хугацаатай албан шаардлага, үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

ж/гадаадал гаргах, гадаадаас авах, тус улсын нутгаар дамжин өнгөрөх ургамал, үр, ургамлын гэрлтай бүтээгдэхүүнд лабораторийн задлан шинжилгээ хийж мэргэжлийн дүгнэлт гаргах;

з/шалгалтаар илэрсэн дутагдал хорио цээрийн болон ургамал хамгаалалтын арга хэмжээний шаардлагыг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

и/хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

к/бүтээгдэхүүний дээж, загварыг тэмдэглэл үйлдэн захиргааны хяналтын эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо хэмжээгээр үнэ төлбөргүй авах, шинжлүүлэх.

12. Байцаагч нь ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын талаар хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, зөрчлийг арилгуулах талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, гэм буруутай этгээдэд Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн заалтыг үндэслэн дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

а/ургамлын хортонтой тэмцэх технологи зөрчсөн, түүнчлэн хортон устгах ажил гүйцэтгэсэн талбайд хорионы хугацаа дуусаагүй байхад аж ахуйн болон бусад үйл ажиллагаа явуулах зэргээр ургамал, хорио цээрийн дэглэм зөрчсөн бол зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийг 120000, албан тушаалтныг 40000, иргэнийг 20000 хүртэл төгрөгөөр торгох;

б/улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-10000, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн албан тушаалтныг 15000 хүртэл төгрөгөөр торгох;

в/хяналт, шалгалтын байгууллага, байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд нь биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-25000, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт шийдвэрт нөлөөлөхийг оролдсон этгээдийг 35000 хүртэл, хяналт шалгалтын холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч бичиг баримт гаргаж өгсөн албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр торгуулах заналаа шүүгчид тавьж шийдвэрлүүлэх.

Дөрөв.Бусад зүйл

13.Ургамал хамгаалал, хорио цээрийн улсын хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж,албан тушаалтан, иргэд хугацаанд нь биелүүлж хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

14.Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно. Уг гомдлыг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

15.Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 228

Улаанбаатар
хот

Нийтлэг журам батлах тухай

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Хууль зүйн сайд

Н.ЛУВСАНЖАВ

ДОТООДЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

1. Энэхүү нийтлэг журмын зорилт нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төсөвт байгууллага, төрийн өмчийн хийгээд төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж /цаашид "байгууллага" гэх/-д дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, аппаратын үйл ажиллагааг хөнгөн шуурхай явуулахад оршино.

2. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, харьяалах дээд шатны байгууллагын болон өөрийн гаргасан шийдвэрийн хэрэгжлт, төлөвлөгөөний биелэлт, хариутай бичгийн шийдвэрлэлт, төрийн өмчийн бүртгэл, тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, байгууллагын дотоодод мөрдөх үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд байнгын хяналт тогтоож, шаардлагатай асуудлаар шалгалт хийн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах үйл ажиллагаа чиглэгдэнэ.

3. Энэхүү нийтлэг журамд нийцүүлэн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг тогтооно.

4. Дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн байгууллагын дарга, Тамгын газар буюу түүнтэй ижил чиг үүрэг бүхий нэгж, ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

5. Дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах үүрэг бүхий нэгж нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

6. Дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулж явуулах жил, хагас жилийн төлөвлөгөөг байгууллагын дарга батална.

7. Дотоодын хяналт шалгалтыг Тамгын газар буюу түүнтэй ижил чиг үүрэг бүхий нэгж, ажилтны санаачилгаар удирдлагын зөвлөлийн шийдвэрээр эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийнэ.

8. Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтыг дор дурдсан журмаар зохион байгуулна:

а/хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн хурал, Засаг даргын хугацаатай болон хугацаа заагаагүй боловч шуурхай арга хэмжээ авах шийдвэрийн холбогдох зүйл, заалт нэг бүрээр Засгийн газрын 1995 оны 53 дугаар тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын дагуу бүртгэл хөгөлж хэрэгжилтийн явцыг улирал тутам удирдлагын зөвлөлд мэдээлж, холбогдох арга хэмжээ авахуулах;

б/бүртгэл хяналтад авсан тогтоол, шийдвэрийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн явц, үр дүн, хэрэв тасарч байгаа бол шалтгааныг тодорхойлсон мэдээг улирал бүрийн эхний сарын 1-ний дотор багтаан холбогдох дээд шатны байгууллагад оруулах.

9. Өөрийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд бүртгэл хяналтын картаар хяналт тавьж сар тутам, байгууллагын төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам гаргаж байгууллагын удирдлагад танилцуулна.

10. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол байгууллагын аппаратын ажилтантай холбогдуулан дотоодын хяналтын журмаар хийх шалгалтыг иргэдийн мэдээлэл, шууд удирдах албан тушаалтны санал, байгууллагын удирдлагын санаачилгаар болон төлөвлөгөөтэйгээр хийнэ.

11. Төрийн өмчийн ашиглалт, бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалтыг дор дурдсан журмаар зохион байгуулна:

а/санхүү тооцооны мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах замаар байгууллагынхаа болон тодорхой нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх;

б/байгууллагынхаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн жил, улирлын тайлан тэнцэлд дүн шинжилгээ хийх;

в/өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын байдалд тооллого явуулах.

12. Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын журмын биелэлтийг шалгахдаа энэ талаархи хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрээр тогтоосон нийтлэг журам, станцартын шаардлага, тэдгээрийг биелүүлэх зорилгоор тухайн байгууллагын захиргаанаас гаргасан шийдвэрийг баримтална.

13. Байгууллагын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын ажлын дун, авсан арга хэмжээний тухай удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шаардлагатай бол зохих шийдвэр гаргаж хамт олонд мэдээлнэ.

14. Дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулсан дүнгийн талаархи тайланг зохих хугацаанд дээд шатны байгууллагад гарган өгч байна.

15. Дотоодын хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажилтан нь хяналт шалгалт явуулахдаа байгууллагын салбар, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс тогтоол шийдвэрийн биелэлт, шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулан танилцах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлбар гаргуулах, зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах талаар байгууллагын удирдлагад санал оруулах эрх эдэлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 242

Улаанбаатар
хот

**Эрүүл мэндийн даатгалын 1996 оны хураамж,
даатгалтай иргэний эмчилгээний зардлын
дээд хязгаарыг тогтоох тухай**

Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2, 3, 7 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан иргэний 1996 онд төлөх эрүүл мэндийн даатгалын сар тутмын хураамжийг тэдний цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 6 хувь, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3-8-д заасан даатгуулагч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч малчны даатгалын сар тутмын хураамжийг дээрх хугацаанд 200 төгрөг байхлар тус тус тогтоож, 3-8-д заасан даатгуулагчийн даатгалын хураамжийг 100 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч малчны даатгалын хураамжийн 50 хувийг төрөөс хариуцан төлж байсугай.

2. "Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 79 дүгээр тогтоолын 2 дугаар заалтад дурдсан

хоригдлын эрүүл мэндийн даатгалын 1996 оны сар тутмын хураамжийг хоригдол бүрт 200 төгрөгөөр тогтоосугай.

3.Төрийн албаны болон төсөвт байгууллагын ажилтны эрүүл мэндийн даатгалын хураамжийн 50 хувийг тухайн байгууллагын төсвөөс гаргаж байсугай.

4.Даатгалтай иргэний эмчилгээний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн төлөх төлбөрийн 1996 онд баримтлах дээд хязгаарыг 350000 төгрөгөөр тогтоосугай.

5.Эрүүл мэндийн даатгалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд 1996 онд шаардагдах хөрөнгийн нормативыг даатгалын орлогын 2,0 хувиар тогтоосугай.

6.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн даатгалын хураамж, даатгалтай иргэний эмчилгээний зардалын хувь, хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 223 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Эрүүл мэндийн сайд

П.НЯМДАВАА

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд

Э.ГОМБОЖАВ

Сангийн сайд

Э.БЯМБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 243

Улаанбаатар
хот

Хүн амын амьжиргааны доод түвшин,
хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Өрхийн нэг хүний амьжиргааны доод түвшинг хотод 8000, хөдөөд 6900 төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Амьжиргааны доод түвшингэй уялдуулан төр, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 49 төгрөг 23 мөнгө байхаар шинэчлэн тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1994 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 163 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд	П.ЖАСРАЙ
Сангийн сайд	Э.БЯМБАЖАВ
Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд	Э.ГОМБОЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 1 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 6

Улаанбаатар
хот

Иод дутлын эмгэгтэй тэмцэх талвар
авах зарим арга хэмжээний тухай

Хүн ам, ялангуяа хүүхэд, өсвөр насныхны бие бялдар, оюун санааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлж буй иод дутлын эмгэгээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, эмчлэх, иод дутлын эмгэгтэй тэмцэх ажлыг хүчтэй болгож устгах, "Хүүхдийн эсэн мэнд өсч бойжих нөхцөлийг хангах, хамгаалах, хөгжүүлэх тухай Дэлхийн дээд хэмжээний уудзалтын тунхаглал", "Дэлхийн хоол тэжээлийн тунхаглал"-д дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. "Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг нэгдүгээр, "Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. "Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ялалт тавьж, биелэлтийг нь хангуулах арга хэмжээ авч ажиллахыг Үндэсний хөгжлийн газар (Ч.УЛААН), Эрүүл мэндийн яам (П.НЯМДАВАА), Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц.ӨӨЛД) -д даалгасугай.

3. Жил бүрийн 9 дүгээр сарын эхний долоо хоногийн ням гаригийг "Иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний өдөр" болгон тэмдэглэж байхаар тогтоосутай.

4. Хүн амын хүнсний хэрэглээнд зориулан стандартын шаардлага хангасан, зохих түвшинд иоджуулсан давс импортлож байх арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авахыг Худалдаа, үйлдвэрийн яам (Ц.ЦОГТ), Гаалийн ерөнхий газар (Б.ШАРАВСАМБУУ)-т даалгасутай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Эрүүл мэндийн сайд

П.НЯМДАВАА

Засгийн газрын 1996 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ИОД ДУТЛЫН ЭМГЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Хүүхдийн төлөө дэлхийн дээд хэмжээний уулзалтаас гаргасан тушаалыг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр, Ромын 1992 оны "Дэлхийн хоол, тэжээлийн тунхаглал"-д дэлхий нийтээрээ 2000 он гэхэд иод дутлын эмгэг (ИДЭ) -ийг устгах зорилтыг дэвшүүлсэн юм.

Дээрх баримт бичгүүдийн үзэл санаа, зорилтыг хүлээн зөвшөөрч нэгдэн орсон улсын хувьд иод дутлын эмгэгийн байдлыг өөрийн оронд судлан тогтоож, хүн амыг уг эмгэгээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах шаардлага хурцаар тавигдаж байна.

Нэг. Монгол Улс дахь иод дутлын эмгэгийн тархалтын өнөөгийн байдал

Монгол Улсад 1960-аад оны сүүтчээс эхлэн иодын дутлаас үүдсэн эмгэгийг голчлон хүүхдийн дунд бамбай булчирхайн томролтыг илрүүлэх байдлаар судалж байв. Энэ чиглэлээр явуулсан хэд хэдэн судалгаанд хамрагдсан хүүхдийн дунд нутагшмал бахлуурын илрэлт 32-45 хувь байсан байна.

Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 1993-1995 онд Монгол Улсын бүх аймаг, хотод 48869 хүнийг хамруулан хийсэн судалгаагаар судалсан хүн амын 29,2 хувьд бамбай булчирхайн томролт илэрсэн байна. Бамбайн үйл ажиллагааны байдал

дээрх судалгаанд хамрагдагсдын 98,5 хувьд зөвнур шаналгаагүй хэвийн, 0,5 хувьд ихсэлтийн, 1,0 хувьд багасалтын шинж тэмдэг давамгайлж байв.

Эх нялхсын эрдэм шинжилгээний төвөөс 1987-1990 онд 14 аймаг, 3 хотын 448642 хүнд хийсэн судалгаанаас үзэхэд 1000 хүн ам тутамд оюун ухааны хомсдолтой 10 хүн илэрснээс үзэхэд улсын хэмжээгээр 21,0 мянга орчим оюун ухааны хомсдолтой хүн байх магадлалтай байна.

Оюун ухааны хомсдолтой хүний тоог бахтуурын тархалтын байдалтай харьцуулан хамаарлыг гаргахад шууд дунд ($t=0,7$) зэргийн хамааралтай байна. Энэ нь иод дутлаас болсон оюун ухааны хомсдол хүн амын дунд тодорхой хувийг эзэлж байгааг харуулж байна.

Дээрх судалгааны дүнг олон улсын түвшинд баримталдаг үзүүлэлтүүдтэй харьцуулахад Монгол орны төвийн уулархаг болон томоохон гол мөрний сав дагуухь нутгуудад иодын дутал хөнгөн хэлбэрээр жигд тархцтай байгаа нь эдгээр нутагт иодын дутлын эмгэг нутагшмал шинжтэй болохыг гэрчилж байна.

Иод дутах нь ураг, нярайн тархи, мэдрэл, сэтгэцийн хөгжилд шууд нөлөөлж, оюун ухааны хомсдол, бие бялдрын хөгжлийн доголдол үүсэх, өсөлт зогсонгиших, хөдөлгөөн саатах эмгэгийн үндсэн шалтгаан болдог.

Оюун ухааны хомсдол, сэтгэцийн өвчин болон бамбай булчирхайн үйл ажиллагааны эмгэг өөрчлөлтийг эмчлэх зардал нь урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгөөс даруй тав дахин их байна.

Хүнсний давс болон хүнсний зарим бүтээгдэхүүнийг иодоор баяжуулах аргыг хэрэглэснээр дэлхийн олон орнууд энэ эмгэгээс хүн амаа найдвартай хамгаалж чадсан байна. Иод дутлын эмгэгтэй тэмцэх энэ арга нь энгийн хялбар, эдийн засгийн хувьд өртөг багатай, хүн амд хүртээмж сайтай, үр дүн нь өндөр байдгаараа онцлог юм.

Хоёр. Давсны үйлдвэрлэлийн байдал

Монгол улсад давсны орд 26 байглагийн 20 ордоос 11 аймаг хүн амын хүнсний хэрэглээ, малын тэжээлийн зориулалтаар давс элборлон ашиглаж байна. Эдгээр давсны ордоос долоо нь нөөц гогтоогдоогүй, дөрөв нь хайгуул хийгдээгүй байна. Мөн ард иргэд эргэн хэрэглэдэг "амны хужир" бүхий 90-ээд уст тойром, мараатай тэсэн мэдээ бий.

Давс олборлон ашиглах үйлдвэрлэл байгаль, цаг уурын байдлаас ихээхэн хамаардаг. Гантай болон хуртай жилд эдгээр үйлдвэрүүдийн ажиллагаа нь үндсэндээ зогсдог бөгөөд технологийн бүхий л үйл ажиллагааг гар аргаар гүйцэтгэж байна.

Монгол Улс 1990 оныг хүртэл жилд дунджаар 7 орд газраас 18,0 мянган тонн давс олборлон, импортоор 3000 тонн давс худалдан авч хүнсний хэрэглээнд болон техникийн зориулалтаар ашиглаж байжээ.

Сүүлийн жилүүдэд давс олборлон ашиглах хэмжээ буурч энэ талаар статистикийн мэдээ, тайлан гараагүй байна. Гэхдээ давс олборлон ашиглаж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, санхүү, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар дотоодын давсны хэрэгцээгээ бүрэн хангах боломжтой гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Монгол Улсын хүн амд шаардагдах иоджуулсан давсны хэрэгцээ нэг жилд 4800-5500 тонн байна (Хүснэгт 1А, 1Б, 1В).

Гурав. Хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлэх арга зам, хугацаа

Монгол Улсын хүн амыг иоджуулсан давсаар тогтмол хангах тогтолцоо бий болгож, улмаар 2001 он хүртэл хугацаанд иод дутлын эмгэгийг устгах арга замыг тодорхойлох, энэ хэрэгт бүх нийтийн хүчин чармайлт, нөөц бололцоог дайчлан ажиллахад хөтөлбөрийн зорилго оршино (Хүснэгт 2).

А. Хэрэгжүүлэх арга зам, үйл ажиллагааны зорилтуул

1. Иод дутлын эмгэгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт тавих үндэсний тогтолцоог бий болгох.

2. Иод дутлын эмгэгээс хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор өргөн олныг хамарсан иоджуулалтыг зохион-байгуулах.

3. Хүнсний болон малын тэжээлд хэрэглэх давсыг дотооддоо үйлдвэрлэн иоджуулах чиглэл баримталж импортоор иоджуулсан давс оруулахыг дэмжих.

4. Иоджуулсан давсыг хүн бүхэнд хүртээмжтэй, чанарын баталгаатайгаар үйлдвэрлэж, нийлүүлэх.

5. Иод дутлын эмгэгийн асуудлаар үндэсний боловсон хүчнийг тодорхой бодлого чиглэлтэй бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх.

6. Иод дутлын эмгэгийг судлах судалгааны ажлыг өргөжүүлж эрт илрүүлэх, эмчлэх, иодын бэлдмэлүүдийг бүс нутгаар ялгавартай хэрэглэх боломжийг бүрдүүлэх.

7. Иод дутлын эмгэгтэй тэмцэх талвар төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоо, мэдээллийн хангамжийг сайжруулах, үндэсний уулзалт, зөвлөлгөөн, хурал, семинар, сургалт зохион байгуулах.

8. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хүн амд иод дутлын эмгэгийн талвар мэдлэг олгох, сурталчилгаа хийх ажлыг байнга, тасралтгүй зохион байгуулж, сайн дурынхныг бэлтгэх.

9. Иод дутлын эмгэгтэй тэмцэх асуудлаар олон улсын байгууллага, хандиалагч улсууд, сайн дурын байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, үйл ажиллагааг нь дэмжих.

Б. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа: 1995-2001 он хүртэл

Хөтөлбөрийг 2001 он хүртэлх хугацаанд дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

1. Өргөн олныг хамарсан иоджуулалтыг иод дутлын эмгэгийн тархалтын байдалтай уялдуулан ялгавартайгаар хийж эхлэх үе: 1995-1996 он.
2. Өргөн олныг хамарсан иоджуулалт хийх үе: 1997-1998 он.
3. Иод дутлын эмгэгийг устгах үе: 1999-2001 он.

Дөрөв.Хөтөлбөрийн удирдлага,зохион байгуулалт

А. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарын гүйцэтгэх ажил

- "Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгийнхаа онцлогт тохирсон дэд хөтөлбөрийг дараахь чиглэлээр боловсруулж ажиллана:

1.Хүн амын дунд иод дутлын эмгэгийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохих заавар, аргачлалын дагуу холбогдох байгууллагуудаар гүйцэтгүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавих.

2.Иод дутлын эмгэгтэй тэмцэх ажилд шаардагдах хөрөнгө, зардлыг жил бүр орон нутгийнхаа төсөвт тусгаж ажиллах.

3.Нутаг дэвсгэртээ байгаа давсны орд газруудын судалгаа гарган, хүн амыг иоджуулсан давсаар хангах бодлого, чиглэлийг годорхойлж, ашиглалтын явцад давсны орд газрын байгалийн гэнцлийг хангах ажлыг зохион байгуулах.

4. Иоджуулсан давс үйлдвэрлэх үйлдвэрүүдийг давсаар байнга тасралтгүй хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

5. Алслагдсан сум, баг болон амьжиргааны доод түвшингээс бага орлоготой, ядуу амьдралтай хүмүүсийг иоджуулсан давсаар хангах арга хэмжээг зохион байгуулах.

6. Иод дутлын эмгэгтэй тэмцэх асуудлаар орон нутгийнхаа хэмжээнд сургалт сурталчилгаа зохион байгуулах.

Б. Төрийн захиргааны төв байгууллагуудын гүйцэтгэх ажил, үүрэг

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР:

- Иод дутлын эмгэгтэй тэмцэх асуудлаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого, чиглэлийг уялдуулан зохицуулна.

- "Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагч улсууд, сайн дурын байгууллагуудын тусламж, дэмжлэгийг чиглүүлнэ.

САНГИЙН ЯАМ:

- "Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн тооцоо үндэслэлийг хянаж, улсын төвлөрсөн төсөвт жил бүр тусгах арга хэмжээ авна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ:

- Иод дутлын эмгэгийн тархалтын байдлыг судлан тогтоож, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавина.

- Иод дутлын эмгэгтэй тэмцэх асуудлаар эрүүл мэндийн байгууллага болон нийгмийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг тодорхойлох, мэдээллээр хангах асуудлыг хариуцна.

- Иоджуулсан давсны үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалт, хэрэглэлтийн байдалд байнгын хяналт тавьж, иодын агууламжийг тодорхойлох арга зүйг эрүүл мэндийн ажилтан, үйлдвэрлэгчид, хүн амд зааж сургах сургалт, сурталчилгаа зохион байгуулна.

ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛЫН ЯАМ:

- Иод дутлын эмгэгээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар бүх шатны сургуульд суралцагсдад анхны мэдэгдэхүүн олгох

ажлыг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

- Иод дутлын эмгэгийг судлах, иоджуулалтын үр дүнг хянах асуудлаархи төслүүдийг сонгон шалгаруулах үндсэн дээр санхүүжүүлнэ.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ:

- Стандартын шаардлага хангасан, зохих түвшинд иоджуулсан давсыг үйлдвэртэй нийлүүлэх асуудлыг хариушна.

- Иоджуулсан давс үйлдвэртэй аж ахуйн нэгжийн боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулна.

- Иоджуулсан давс үйлдвэртэй аж ахуйн нэгжүүдийн техникийн шинэчлэлтийн асуудалд мэргэжлийн туслалцаа үзүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, түүхий эдээр хангах ажлыг зохион байгуулж хяналт тавина.

- Иоджуулсан давсны үйлдвэртэй, хуваарилалт, тээвэртэй, борлуулалтын мэдээг холбогдох байгууллагуудын оролцоотойгоор улирал тутамд гаргуулах ажлыг зохион байгуулна.

- Малын тэжээлийн давсыг иоджуулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран судалж шийдвэртэнэ.

ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ЯАМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ:

- Иоджуулсан давс үйлдвэртэй аж ахуйн нэгжид давсны орд газрыг ашиглуулах тусгай зөвшөөрөл олгож орд газрын ашиглалтад технологийн хяналт тавьж ажиллана.

- Давс олборлолтыг байгалийн тэнцлийг алдагдуулахгүйгээр зохион байгуулж, давс байгалийн аясаар бүрэлдэн тогтох нөхцөлийг хангах, усны халиа, тошин, элсний нүүлтээс хамгаалах асуудлаар сургалт, сурталчилгаа зохион байгуулна.

В. Төрийн бус байгууллагуудын оролцоо

- Иод дутлын эмгэг, түүний хор уршгийг гишүүн байгууллага, иргэдэд сурталчлан тайлбарлах.

- Иоджуулсан давсыг ашиглах, хэрэглэх талаар сургалт, сурталчилгаа хийх, сайн дурынхныг бэлтгэх ажлыг зохион байгуулах.

- Иоджуулсан давсны үйлдвэртэй, тээвэртэй, хуваарилалт, сэдгалалт, борлуулалт, хэрэглээний байдалд гишүүн байгууллага,

иргэдийн хүч, оролцоотой хяналт тавьж, зөрчил дутагдлыг холбогдох байгууллагуудад мэдээлж байх.

- Иод дутлын эмгэгээс урьдчилан сэргийлэх, иоджуулсан давс хэрэглэхийн ач холбогдлыг сурталчлах асуудлаар олон нийтийн дунд ярилцлага, уулзалт зэргийг зохион байгуулж, ивээн тэтгэх үйл ажиллагааг өрнүүлэх.

Г. Иргэд, олон нийтийн үүрэг

- Иргэн бүр иод дутлаас сэргийлэх аргыг эзэмшиж, иоджуулсан давсыг зөв хэрэглэж, хадгалж занших, үр хүүхэд, өндөр настнуудыг иоджуулсан давс хэрэглэж сургах.

- Иоджуулсан давсыг худалдан авах хэрэглэхдээ чанарын баталгааг шалгаж, үйлдвэрлэгч, худалдан борлуулагчийн буруу үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хяналтын байгууллагуудад тухай бүр өгч байх.

Тав. Эрүүл мэндийн байгууллагуудаас иод дутлын эмгэгтэй тэмцэх ажлын үндсэн чиглэл

А. Иод дутлын эмгэгээс урьдчилан сэргийлэх:

- Иоджуулсан давсыг хүнсэнд хэрэглэх нь иод дутлын эмгэгээс урьдчилан сэргийлэх үндсэн арга болно.

- Иодын тосон бэлдмэлийг аргачлалын дагуу шаардлагатай газруудад нэмэлтээр хэрэглэнэ.

Б. Иод дутлын эмгэгийг илрүүлэх:

- Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага, өрхийн эмч нар нутаг дэвсгэрийнхээ хүн ам, ялангуяа бага насны хүүхэд, төрөх насны эмэгтэйчүүдэд нутагшмал бахлуур илрүүлэх үзлэг хийж өвчлөлийн түвшин, тархалтыг тогтоох.

- Ерөнхий боловсролын сургуулийн 7-12 насны тодорхой тооны (300-гаас доошгүй) сурагчдад дээрх үзлэгийг жил бүр давтан хийж урьдчилан сэргийлэлтийн явц, үр дүнг хянах.

- Эмнэл зүйн үзлэгээр нярай болон бага насны хүүхдийн дунд төрөлхийн бамбайн дутал (кретин), бамбайн доройтол (гипотиреоз) байгаа эсэхийг илрүүлэхэд анхаарах.

- Иод дутлаас үүдсэн бамбай булчирхайн томролтыг бусад эмгэг томролтоос ялган оношлох.

- Лабораторийн хүчин чадал боломжтой газруудад цус, шээсэнд иод тодорхойлох шинжилгээ хийх.

В. Иод дутлын эмгэгийг эмчлэх:

- Иоджуулсан давсыг тогтмол, байнга хэрэглэх нь иод дутлаас үүдэх аливаа эмгэгээс урьдчилан сэргийлэх үндсэн арга болно.
- Бамбай булчирхай хэт томорсон, зангилаа үүссэн тохиолдолд мэс заслын аргаар эмчилнэ.
- Бамбайн доройтол илэрсэн хүмүүсийг мэргэжлийн эмчийн байнгын хяналтад эмчилнэ.

IV. Лабораторийн болон онош зүйн шинжилгээ

Иод дутлын эмгэгийг эмчлэх, урьдчилан сэргийлэх, ялган оношлох, эмчилгээний үр дүнг хянахад лабораторийн болон онош зүйн шинжилгээ нэн чухал болно.

- Лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх болон одоогийн суурилагдсан техник, хэрэгслийг ашиглах замаар 1996 оноос эхлэн дараахь шинжилгээг нийслэл, аймаг, дүүргийн клиникийн болон нэгдсэн эмнэлгүүдэд хийнэ:

НИЙСЛЭЛ, АЙМАГ, ДҮҮРГИЙН КЛИНИКИЙН БОЛОН НЭГДСЭН ЭМНЭЛГҮҮДЭД ХИЙГДЭХ ШИНЖИЛГЭЭ

№	Нэр	Бамбайг сэдээгч даавар /TSH/-ыг нярайн хүйн цусанд тодорхойлох	Шээсэн дэх иодыг тодорхойлох	Цусанд бамбайн даавар T3, T4-ийг тодорхойлох	Бамбай булчирхайг хэт автагаар оношлох
1	Клиникийн эмнэлэгт	+	+	+	+
2	Нэгдсэн эмнэлэгт	-	+	-	+

-Хүрээлэн байгаа орчин, хүнсний зүйлд иодын агууламж одорхойлох лабораторийн шинжилгээ хийх хүрээг өргөтгөнө.

- Иоджуулсан давс үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, борлуулах, хэрэглэх түвшинд иодын агууламж тодорхойлоход лабораторийн арга болон хурдавчилсан шалгуурыг ашиглан хяналт тавина.

Зургаа. Давс иоджуулах ажлыг эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх ажил

- Давсны орд газрыг ашиглах тусгай зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас авна.
- Давс олборлон бэлтгэхдээ давсны орд газрын ашиглалтын горимыг байнга мөрдөж байгалийн тэнцлийг алдагдуулахгүйгээр үйлдвэрлэлээ хөтлөн явуулна.
- Үндэсний хөгжлийн газар, Эрүүл мэндийн яам, Үндэсний стандарт, хэмжил зүйн төвөөс давс иоджуулах талаар гаргасан тушаал, заавар, аргачлал, стандартыг мөрдлөг болгон иоджуулсан давсны үйлдвэрлэлийг эрхлэн гүйцэтгэнэ.
- Иоджуулахад тохирохуйц давсны байнгын нөөцтэй байна.
- Давс олборлох, иоджуулах, тээвэрлэх, хадгалах, савлах үйлдвэрлэлийн технологи нь стандартын шаардлага хангасан байна.
- Иоджуулсан давс үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүд иодын агууламжийг тодорхойлох чанарын хяналтын лабораторитой байж, үйлдвэрлэлийн явцад байнгын хяналт тавина.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

- Иод дутлын эмгэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэх судалгаа, шинжилгээний ажлыг сонгон шалгаруулж төсвөөс санхүүжүүлнэ.

- Иоджуулсан давс үйлдвэрлэх аж ахуйн нэгжилд зохио журмаар зээл олгож, шашид бие дааж үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

-Боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх арга хэмжээг төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгө, олон улсын байгууллага, хандивлагч улсуудын тусламж дэмжлэгээр гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр тодотгон тооцоолж холбогдох байгууллагуудтай тохиролцон зохицуулж байна (Хүснэгт 3).

Найм. Хөтөлбөрийн хяналт, үнэлэлт дүгнэлт

"Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны

үндсэн зорилго нь иод дутлын эмгэгийн байдлыг хянах, танзан судлах, үнэтэлт дүгнэлт өгөх, иоджуулсан бүтээгдэхүүнд чанарын хяналт тавих, боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, хөрөнгө, санхүүгийн нөөцийг хуваарилах, олон улсын байгууллага, хандивлагч улсууд, сонирхогч байгууллагуудтай хамтран ажиллах асуудлыг уялдуулан зохицуулж, хөрөнгийн нөөцийг хамгийн үр ашигтай, үр дүнтэй зарцуулахад чиглүүлэх явдал болно.

Зохицуулах зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил бүр дүгнэж Засгийн газарт тайлагнана. Мөн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар олон нийтэд болон олон улсын хэмжээнд мэдээлэх, сурталчилах ажлыг зохион байгуулна.

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцтай уялдуулан энэхүү хөтөлбөрт нэмэлт, тодотгол оруулж байх болно.

ИИД ДУТЛЫН ЭМГЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сургах мөргөжлийн чиглэл	1996	1997	1998	1999	2000	Хугацаа
1.	Дэвж илгээхэд технологийн асуудал	20	-	-	-	-	12 хоног
2.	Дэлхийн үйлдвэрийн улиралд юуныг байгуулах	10	-	-	-	-	14 хоног
3.	Нэгжүүлсэн ажлын цэвэрлэн хөдөл	25	25	10	-	-	14 хоног
4.	Лабораторийн үндэст	20	20	-	-	-	1 сар
5.	Инд дуулын эмгэгтэй тэмцэх асуудалар дот гарын мэргэжил нэгдэх курс	35	-	-	-	-	2 сар
6.	Мэдээлэл, сурталчилгаа	25	25	25	25	-	14 хоног
7.	Инд дуулын эмгэгтэй тэмцэх механикийн удирдлага, зохион байгуулалт	1	-	1	-	-	2 сар
8.	Инд дуулын эмгэгтэй тэмцэх үндэст өсөл	1	1	-	-	-	3 сар
9.	Нэгжүүлсэн ажлын цэвэрлэн хөдөлтийн өргөтгөл дот үрб	2	2	2	2	-	21 хоног
10.	Лабораторийн хөдөл, үндэст	2	2	1	-	-	2 сар
11.	Нэгжүүлсэн ажлын үндэвэрлэн ийн технологийн	3	3	-	-	-	14 хоног
12.	Инд дуулын эмгэгт үржүүлсэн сурталчилгаа, сурталчилгаа	2	2	2	-	-	14 хоног

Ес Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Д.э	Хэрэгжүүлэх эрэл хэмжээ	1996	1997	1998	1999	2000	Хариуцах байгуулалтыг, албан тушаалтан	Хамтран ажиглах байгуулалтыг
А	1	2	3	4	5	6	7	8
1	Нөд дугуйн эмэгтэйн тэнцэх, урьдчилан сурталлах суртал-чингээ, сургалтын ажлыг түстэй төлөвтөгөөгөөр зохион явуулах	+	+	+	+	+	Зохилцуулах мөчлөг	Эрүүл мэндийн яам, хэвлэлийн байгууллагууд
2	Полжүүлж ажлаа үйлдвэрлэх, үндэслэлтэй, эрэгтэжээний талаархи аар сурталчилгааг өргөтгөхөөр эрэл хэмжээ авах	+	+	+	+	+	Зохилцуулах мөчлөг	Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам, хэвлэлийн байгууллагууд
3	Нөд дугуйн эмэгтэйн асуудлаар шинжлэх ухааны гэрн буй ололт, амжилтыг нэгж жад тусам мэдээлэх, мэдээллийг нэвтрүүлэх	+	+	+	+	+	Зохилцуулах мөчлөг	Эрүүл мэндийн яам, хэвлэлийн байгууллагууд
4	Нөд дугуйн эмэгтэйн хянах дэлгэрэнгүй тунгш төхөөрөмж, нөдмөн тосон бэлэмийг нийлүүлдэг	+	+	+	+	+	Үйлдвэрний хөгжлийн гэрлэр, Эрүүл мэндийн яам	
5	Боловсон хүчин бэлтгэх, сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	+	+	+	+	+	Эрүүл мэндийн яам	Галлах хариуцлагын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам
6	Улаанбаатар хот, Дорнод, Завхан, Дорнод-Уул, Увс, Өмнөговь аймагт нэгжүүлсэн давс үйлдвэрлэх төхөөрөмжийг суусруулах	+					Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам	

А	1	2	3	4	5	6	7	8
7	Хята, Баянхонгор, Говь-алтай аймгаг даав ноджуулах тоног төлөөрөөх аюулаж миндүүрэх	+					Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам	
8	Ноджуулсан даав үйлдвэрлэгчдийг түүхий эвлэр хангах	+	+	+	+	+	Бүх шатны Засаг дарга нар	НУБ-ын Хүүхдийн сан, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Хуудалдаа, үйлдвэрлэлийн яам
9	Улаанбаатар хот, Дорнод, Завхан, Дархан-уул, Увс, Өмнөговь аймгийн ноджуулсан даавны үйлдвэрүүдэд ашигласан аюулын лабораторийг байгуулах	+					Хүнс, хөдөө аж ахуйн яам	Эрүүл мэндийн яам, Хүнс, үйлдвэрлэлийн яам
10	Нод агуулан ашигласан талхорон чадаргаа нуглуулах, суулагтаа шийх, дундагт түргэт	+	+	+	+	+	Зориуулах зөвлөл	Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам,
11	Нод агуулан ашигласан үйлдвэр суулагтаа аюулах, лабораторийн шинжилгээг тогтоожуулах ажлаа хангалттай хийж ажиллах	+	+	+	+	+	Эрүүл мэндийн яам	Орон нутгийн засагтаа
12	Ноджуулсан даавны үйлдвэрлэл, тээвэрлэл, хангалат борлуулалт болон баталгаатай бүтээгдэхүүнээр хүү ашиг хангах үйл ажиллагааг хангалттай хийж ажиллуулах	+	+	+	+	+	Хүнс, хөдөө аж ахуйн яам	Хуудалдаа, үйлдвэрлэлийн яам, Эрүүл мэндийн яам, орон нутгийн засагтаа
13	ТЭН дээрх шинжлэх лаборатори байгуулах арга хэмжээ авах	+				+	Эрүүл мэндийн яам	Үндэсний хөгжлийн газар
14	Хятаборны хэрэгжлэлийн аюулыг жил бүр улсын хэмжээгээр мэдгэн дүнлэж Засгийн газарт байрлуулж байх	+	+	+	+	+	Зориуулах зөвлөл	Үндэсний хөгжлийн газар, Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Хуудалдаа, үйлдвэрлэлийн яам

**НИЙСЛЭЛ, АЙМГУУДАЛ ИОДЖУУЛСАН ДАВС
НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ**

Иоджуулсан давс нийлүүлэх үйлдвэр, компани	Нийлүүлэх давс /тонноор/	Бүгд
Увс аймгийн ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн давсны үйлдвэр	Увсад 205 Баян-өлгийд 205 Ховдод 186 Хөвсгөлд 150	746
Завхан аймгийн "Баялаг" хувьцаат компани	Завханд 215 Говь-алтайд 160 Баянхонгор 195 Архангайд 205 Хөвсгөлд 100	875
Өмнөговь аймгийн хүнсний үйлдвэр	Өвөрхангайд 235 Дундговьд 125 Дорноговьд 110 Өмнөговьд 105	575
Улаанбаатар хотын "Хүнс-Маш" хувьцаат компани	Улаанбаатар 1280 Төлд 250	1530
Дархан-уул аймгийн хүнсний үйлдвэр	Булганд 140 Орхонд 120 Сэлэнгэд 205 Дархан-уулд 190	655
Дорнод аймгийн "Дорнод хүнс" хувьцаат компани	Дорнодод 180 Сүхбаатар 125 Хэнтийд 170	475
		4856

**ИОДЖУУЛСАН ДАВС ҮЙЛДВЭРЛЭХ ҮЙЛДВЭРҮҮДИЙН
ЖИЛД ГАРГАХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ,
ИОДЫН ХЭРЭГЦЭЭ**

• Иоджуулсан давс үйлдвэрлэх үйлдвэрийн байршил	Жилд үйлдвэрлэх иоджуулсан давс /тн-оор/	Иоджуулсан давс үйлдвэрлэхэд шаардагдох иодын хэрэгцээ /кг-аар/
Дархан-уул	655	55,7
Дорнод	475	40,4
Завхан	875	74,4
Өмнөговь	575	49,0
Увс	746	63,5
Улаанбаатар	1530	130,0
Ховд	100	8,5
Баянхонгор	150	13,0
Говь-алтай	150	13,0
Бүгд	5256	448 /+4,5 кг/

ТАЙЛБАР: Калий нодатын хэрэгцээ жилд 448 кг бөгөөд үйлдвэрлэлийн технологийн алдагдлыг 10 хувиар тооцов.

**ИОД ДУТЛЫН ЭМГЭГ НУТАГШМАЛ ХЭЛБЭРЭЭР ИЛЭРЧ
БАЙГАА АЙМГУУДЫН МАЛД ШААРДАГДАХ
ИОДЖУУЛСАН ДАВСНЫ ХЭРЭГЦЭЭ**

№	Аймгуудын нэр	Малын тоо мян. толгой	Иод-жуулсан давс /гн-оор/	Үүнээс			
				Бод		Бог	
				Тоо мян./тол	Давс тонн	Тоо мян./тол	Давс тонн
1	Хөвсгөл	1111,5	266,5	248,8	123,1	862,7	143,4
2	Архангай	1017,5	245,4	233,7	115,7	783,8	129,7
3	Баян-Өлгий	936,0	181,6	82,3	40,5	41,0	6,8
4	Баянхонгор	257,0	62,1	59,9	29,6	197,1	32,5
5	Дорнод	517,6	115,2	90,4	44,6	427,2	70,6
6	Завхан	391,6	88,5	72,7	35,9	318,9	52,6
7	Өвөрхангай	348,3	83,5	78,5	38,9	269,8	44,6
8	Сэлэнгэ	418,9	97,4	85,8	42,4	333,1	54,9
9	Төв	262,8	60,7	52,5	25,9	210,3	34,8
10	Ховд	154,3	31,4	17,8	8,8	136,5	22,6
11	Увс	300,0	60,7	33,8	16,7	266,2	44,0
12	Хэнтий	546,1	121,2	94,3	46,7	451,8	74,5
13	Булган	281,8	66,0	59,5	29,4	222,3	36,6
	Бүгд	6544,0	1481,0	1210,0	599,0	4521,0	748,0

**ИОД ДУТЛЫН ЭМГЭГТЭЙ ТЭМЦЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГ-
ЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ҮР ДҮН**

№	Үзүүлэлтүүд	1995	1997	2000
1	Бахлуур өвчний илрэлтийн байдал /7-14/ нас	28%	15%	0,5%
2	Иоджуулсан давсаар хүн амыг хангах	10%	70%	95%

**ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТООЦОО**

/Ам.доллараар/

Д/д	Эх үүсвэр	Шаардагдах хөрөнгө онуудаар				Бүгд
		1996	1997	1998	1999	
1	Улсын төсөв	20000	10000	10000	10000	50000
2	Банкны зээл	20000	10000	10000	10000	50000
3	Үйлдвэрлэгчид	10000	10000	10000	10000	40000
4	Олон улсын байгууллага, хандивлагчид	255000	185000	60000	60000	560000
	Бүгд	305000	215000	90000	90000	700000

Засгийн газрын 1996 оны 6 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт.

**ИОД ДУТЛЫН ЭМГЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- | | |
|--------------------------|--|
| Үндэсний зөвлөлийн дарга | -Үндэсний хөгжлийн газрын дэд дарга |
| Орлогч дарга | -Эрүүл мэндийн дэд сайд |
| Нарийн бичгийн дарга | -Эрүүл мэндийн яамны хоол тэжээлийн асуудал хариуцсан дэс түшмэл |
| Гишүүд | -Байгаль орчны яамны Байгалийн нөөцийн бодлогын газрын дарга; |
| | -Дэд бүтцийн хөгжлийн яамны Тээврийн газрын ерөнхий захирал; |
| | -Сангийн яамны Төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн газрын орлогч дарга; |
| | -Худалдаа үйлдвэрийн яамны Олон улсын худалдаа, хамтын ажиллагааны газрын захирал; |
| | -Худалдаа үйлдвэрийн яамны Худалдааны улсын хянан бэйцаах газрын дарга; |
| | -Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны Хүн амын бодлогын газрын ерөнхий захирал; |
| | -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хүнсний газрын ерөнхий захирал; |
| | -Шинжлэх ухаан боловсролын яамны Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын дарга; |

- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга;
- Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Уул уурхайн газрын ерөнхий захирал;
- Гаалийн ерөнхий газрын Тариф, хамтан ажиллагааны хэлтсийн дарга;
- Татварын ерөнхий газрын Бодлого, аргачлалын хэлтсийн дарга;
- Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дэд дарга;
- Анагаах ухааны их сургуулийн захирал;
- Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн (зөвшилцөн тохиролцсоноор);
- Улсын мал эмнэлгийн албыг удирдах газрын дарга;
- Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн захирал;
- Хоол судлалын төвийн захирал;
- Эрүүл ахуй, халдвар, нян судлалын Үндэсний төвийн захирал.